

“АШИГТ МАЛТМАЛЫГ БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРЭМ”-ИЙН ТӨСӨЛ

Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсад мөн түүнчлэн шинээр барих, сэргээн босгох үйлдвэрийн зураг төсөл ж байгаа эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагын ажилтнууд дагаж мөрдөх үүрэгтэй.

Агуулга

Бүлэг - I Ерөнхий зүйл.....	4
1.1. Дүрмийг хэрэглэх хүрээ, журам	4
Бүлэг - II Аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага	7
2.1. Эрүүл ахуйн шаардлага	7
2.2. Аюулгүй ажиллагаа	9
2.2.1. Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохио, хаалт хашилт	9
2.2.2. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл	9
2.2.3. Галын аюулгүй байдал.....	9
2.2.5. Аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ	10
2.2.6. Ажлын байрны үзлэг шалгалт	10
2.2.7. Засвар, угсралт, үйлчилгээний болон зөөврийн ажил.....	10
2.2.7.1. Тоног төхөөрөмжийн тусгаарлалт.....	11
2.2.7.2. Тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэг	12
2.2.7.3. Засварын ажил	12
2.2.7.4. Хийн ил дөлтэй ажил	14
2.2.8. Тоос (тоос барих систем), хий цэвэрлэх систем	16
2.2.9. Агааржуулалт	16
2.2.10. Гэрэлтүүлэг	18
2.2.11. Эргономик, Ажлын талбар, ажлын байрны эмх цэгц,.....	18
2.2.12. Дуу, шуугиан.....	19
Бүлэг - III Баяжуулалт.....	19
3.1. Материал хүлээн авалт, бутлалт, нунтаглалт.....	19
3.1.1. Хүдрийг зөөвөрлөх, хүлээн авах ба завсрын бункер	19
3.1.2. Бутлалт	20
3.1.2.1. Мышьякийн ангидридийн үйлдвэрлэл, хүхрийн хүдрийг бэлтгэхэд мөрдөх нэмэлт шаардлагууд.....	21
3.1.3. Нунтаглалт ба ангилалт.....	21
3.2. Баяжуулах үйл ажиллагаа.....	22
3.2.1. Гравитац (Хүндийн хүч)	22
3.2.1.1. Шороон ордын баяжуулалт	22
3.2.2. Хөвүүлэн баяжуулалт (Флотац).....	23

3.2.3. Радиометр, рентген-люминесценц	23
3.2.4. Соронзон ба цахилгаан арга	23
Бүлэг - IV Боловсруулалт	24
4.1. Гидрометаллурги	24
4.1.1. Даралтат тоног төхөөрөмж	27
4.1.2. Шингээх, шингээлтийг алдагдуулах, сэргээх ба электролиз	28
4.2. Дулааны аргаар боловсруулах	29
4.2.1. Хатаах, ууршуулах	29
4.2.2. Бөөнцөглөх ба бөөгнөрүүлэх, ангижруулах шатаалтын төхөөрөмжүүд ба хатаах хэсэг	30
4.2.2.1. Бөөнцөглөх ба бөөгнөрүүлэх	30
4.2.2.2. Ангижруулах шатаалтын төхөөрөмж	38
4.2.2.3. Хатаах тасаг	38
Бүлэг - V Үйлдвэрийн тээвэр	39
5.1. Технологийн тээвэр	39
5.2. Тасралтгүй тээвэр (туузан дамжуулагчид, шугам хоолойгоор дамжуулах-хийн, шингэн, булингын-slurry)	40
Бүлэг - VI Хаягдлын аж ахуй	43
Бүлэг - VII Туслах үйл ажиллагаа	44
7.1. Усгүйжүүлэх	44
7.1.1. Өтгөрүүлэх	44
7.1.2. Шүүх	45
7.2. Хүдэр, баяжмал болон хүдрийн бус материалын агуулах	45
а. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний сорьцлолт, савлалтад тавих шаардлага	46
Бүлэг - VIII Дүрэм зөрчигчдөд	47
хүлээлгэх хариуцлага	47

Бүлэг - I Ерөнхий зүйл

1.1. Дүрмийг хэрэглэх хүрээ, журам

1. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулдаг эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллага, үйлдвэрийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, тэдгээрийн ажиллагсад энэ дүрмийг дагаж мөрдөнө.
2. Шинээр барьж эхэлсэн буюу өргөтгөн шинэчлэгдэж байгаа үйлдвэр нь батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ-ийн дагуу баригдсан байна. Үйлдвэр нь барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байнгын хяналттай байна. Хяналтыг хэрэгжүүлэх журмыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан баталсан байна.
3. Тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх эрсдэлтэй ажлын жагсаалтыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална.
4. Үйлдвэрийн хэсэг тус бүрт галын ба тэсэрч дэлбэрэх аюулын зэрэглэлийг тогтоож, тогтоогдсон зэрэглэлийг-үндэслэн шаардагдах аюулгүйн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
5. Байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоотой байна.
6. Байгууллага нь тоног төхөөрөмжийн ашиглалтын, аюулгүй байдлын болон үйлдвэрлэлийн ажиллагааг харуулсан технологийн заавар, зураглалтай байна.
7. Шинээр ажилд орж байгаа, нэг ажлаас нөгөө ажилд шилжиж байгаа ажиятан ажилтныг мэргэжлийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж чадах, эсэхийг тодорхойлох зорилгоор эмнэлгийн үзлэгт оруулна.
8. Ажиллагдсыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу эмнэлгийн үзлэгт оруулна.
9. Шинээр ажилд орж байгаа болон ажлын байр нь өөрчлөгдсөн ажилтан нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.
10. Ажилтан нь ажилд орохоос өмнө аюулгүй ажиллагааны урьдчилсан сургалтад хамрагдаж, шалгалт өгнө. Хуучин ажиллаж байсан, буюу зохих мэргэжилтэй хүмүүсээс бусад ажилтан аюулгүй ажиллагааны урьдчилсан сургалтаар шалгалт өгсний дараа мэргэжлийн сургалтад хамрагдах буюу зарим тохиолдолд ганцаарчилсан журмаар туршлагатай ажилтанд хариуцуулан тодорхой хугацаанд, тусгай хөтөлбөрийн дагуу дагалдан суралцана. Дагалдангаар ажиллах хугацаагаа дуусгаад шалгалт өгсний дараа мэргэжлийн дагуу бие даан ажиллахыг зөвшөөрнө. Тусгай хөтөлбөрийн дагуу явагдах сургалтын хугацааг дууссаны дараа шалгалт өгч, тохирох мэргэжлийн үнэмлэх авсан хүнийг машин тоног төхөөрөмж, эд анги дээр бие даан ажиллахыг зөвшөөрнө. Ажилд

дахин орж байгаа буюу өөр ажилд шилжиж байгаа ажилчид нь ажилд орохын өмнө баталсан хөтөлбөрийн дагуу аюулгүй ажиллагааны талаар ажлын байрны зааварчилга авна. Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг удирдах ажилтан өгч аюулгүй ажиллагааны хувийн хэрэгт буюу тусгай дэвтэрт бүртгэж, тэмдэглэнэ.

11. Их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан үйлдвэрлэлийн дадлага хийхийн өмнө аюулгүй ажиллагааны хоёр өдрийн сургалтад хамрагдаж, шалгалт өгнө.

12. Бүх ажилтан цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, хурц хордлогод өртөх, осолд нэрвэгдэгсдэд анхны тусламжийг түргэн шуурхай үзүүлэх арга барилд суралцсан байх ба зааварчилга авсан байна. Химийн хортой болон аюултай бодистой харьцаж ажилладаг ажилтан нь тусгай сургалтад хамрагдаж, шалгалт өгнө.

13. Ажилтан ажил эхлэхийн өмнө ажлын байрны аюулгүй байдлыг хянаж, хамгаалах төхөөрөмжүүд, багаж механизм ба бусад ажлын хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгана. Аюулгүй ажиллагааг хангаж чадахгүй нөхцөл үүссэн тохиолдолд өөрийн шууд удирдах албан тушаалтанд мэдэгдэнэ.

14. Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэмд заасан группын ангилалтай ажилтныг цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийхийг зөвшөөрнө.

15. Ажилтанд аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг хагас жилд нэг удаа өгч, аюулгүй ажиллагааны хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлнө. Техник, технологи өөрчлөгдсөн болон шинэ аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөх үед ээлжит бус зааварчилгааг өгнө.

16. Ажил олгогч нь ажилтныг тухайн ажлын нөхцөлд тохирсон стандарт шаардлага хангасан ажлын тусгай хувцас, гутал, хувийн хамгаалах хэрэгслээр тогтоогдсон нормын дагуу хангана. Хорт хийн баг, амьсгал хамгаалах хэрэгслийн (нэг удаа хэрэглэхээс бусад) ашиглалтын хугацааг бүртгэж, тэдгээрт байнгын үзлэг хийж, шаардлагатай бол солино.

17. Үйлдвэрийн технологийн үйл ажиллагааг мэргэжлийн дээд, тусгай дунд боловсролтой инженер техникийн ажилтан удирдан явуулна.

18. Ажил хуваарилах өрөө, ажлын байр, тоног төхөөрөмжийн дэргэд болон явган хүний зам зэрэг газруудад зохих тэмдэг, зурагт хуудсуудыг байрлуулсан байна.

19. Ажлын байр нь цэвэр, эмх цэгцтэй бөгөөд орц гарцууд саадгүй чөлөөтэй байна. Машины эд анги, элдэв материал, үйлдвэрлэлийн хаягдлыг ажлын байрнаас зайтай тусгай зориулалтын цэгт хадгална.

20. Ажлын байранд тамхи татах, хооллох, ундлахыг хориглоно.

21. Технологийн усыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

22. Ажилтан нь ажил мэргэжил болон хөдөлмөрийн нөхцөлд тохирсон, стандартад нийцсэн ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж зориулалтын дагуу бүрэн, зөв хэрэглэх үүрэгтэй.

23. Ажилтан нь үйлдвэрийн бүсэд зөвхөн зориулалтын зам, шат, талбайгаар явах ба шугам хоолой, хаалт хашлага, ховил, тоног төхөөрөмж дээгүүр давахыг хориглоно.
24. Үйлдвэрлэлийн талбай, явуулын гүүр, шат нь бат бөх тогтвортой хийгдсэн байхаас гадна 1 метрээс багагүй өндөртэй хашлагатай байна. Хашлагын доод талаас 0.14 метр өндөрт хөндлөвч буюу битүү хаалт хийсэн байна. Ажлын талбай нь 0.3 метрээс дээш өндөрт байрлагдсан байвал хашлага хийж хамгаалсан байхаас гадна шат заавал байна. Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний талбай, шатны тавцан нь ус, хог шороо хуримтлагдахгүй байхаар хийгдсэн байна.
25. Тоног төхөөрөмж болон ажлын талбайд хэрэглэх шатны налуу нь:
- а. байнгын ашиглалтад байгаа бол 45° -аас ихгүй,
 - б. ээлжид 1-2 удаа хэрэглэх үед 60° -аас ихгүй,
 - в. худаг, зумпфэнд хэрэглэх бол 90° хүртэл тус тус байж болно.
26. Бүх тохиолдолд шатны өргөн нь 0.6 метрээс багагүй, гишгүүрийн хоорондох өндөр нь 0.3 метрээс их бус, өргөн нь 0.25 метрээс багагүй байх шаардлагатай. Шатны гишгүүр, тавцанг халтирахаас сэргийлсэн материалаар хийнэ. Худаг ба зумпфны хананд бэхэлсэн гишгүүрүүд хэрэглэхийг зөвшөөрнө.
27. Үйлдвэрлэлийн талбай, байранд орших бүх суваг шуудуу, худаг, тосгуур угсралтын нүх хонхрууд зэрэгт 1 метрээс багагүй өндөртэй хамгаалах хашлага хийж, хашлагын доор 0.14 метр өндөр хаалт хийх ба хөндлөн гарц нь 1 метрээс багагүй өргөнтэй дамжих гүүртэй байна.
- Тайлбар: Ус татах хоолой, суваг шуудуу, худаг, нүх хонхор нь шалтай тэгш битүү хучсан тохиолдолд хашлага хэрэглэхгүй.
28. Дамжуулах хоолой, ховил нь ажлын байр талбайд саад тотгор болохооргүй байна. Хэрэв ажлын талбай, зам гарцыг огтлон гарсан тохиолдолд дамжуулах хоолой, ховилыг шалнаас 1.8 метрээс доошгүй өндөрт байрлуулна. Ажлын байр, талбайн дээгүүр хөндлөн гарсан урвалж дамжуулах хоолойг дагасан асгаралтаас хамгаалах ховилтой байх ба шалнаас ховил хүртэлх зай 2 м-ээс багагүй байна.
29. Агаар, усны даралтаар ажилладаг автомат удирдлагагүй төхөөрөмж (хаалт, шалгах, хэмжих багаж) нь шалнаас 1.5 метрээс дээш байрласан бол 0.8 метрээс багагүй өргөнтэй байнгын ажлын талбайтай байна.
30. Зэрэгцээ орших тоног төхөөрөмжийн хоорондын болон хана хүртэлх хамгийн бага зай нь:
- а. Хүн зорчих үндсэн замаас 1.5 метр;
 - б. Ажилтан засвар, үйлчилгээ хийх шаардлагатай бол тоног төхөөрөмж хоорондын зай 1 метр;
 - в. Хүн зорчих бол тоног төхөөрөмжөөс хана хүртэлх зай нь 0.7 метр;

г. Ган, сав зэрэгт засвар үйлчилгээ хийхэд зориулагдсан зай нь 0.6 метр байна.

Тайлбар: Хамгийн бага зай гэдэг нь тоног төхөөрөмжийн хаалт, хамгаалалт, суурь, овроос илүү гарсан эд анги, хана тэдгээрт бэхлэгдсэн хоолой, төхөөрөмж гэх мэтийг оруулан тооцсон хэмжээг хэлнэ.

31. Тоног төхөөрөмжийн засварт хэрэглэх том хэмжээний эд ангиудыг тээвэрлэх замын өргөн нь тээвэрлэгдэж байгаа хамгийн өргөн эд ангийн хэмжээнээс хоёр тийш 0.6 метрээс багагүй зайтай байна.

32. Осол, гэмтэл гарсан тохиолдолд осолд нэрвэгдсэн хүн өөрөө эсвэл түүнийг харсан гэрч тухайн үйлдвэрт мөрдөгдөж байгаа журмын дагуу холбогдох албан тушаалтанд яаралтай мэдэгдэнэ. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлыг “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу шийдвэрлэнэ.

33. Үйлдвэрт ажил үйлчилгээг туслан гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэгч нь энэхүү дүрмийг мөрдөх бөгөөд дүрмийн биелэлтийн талаар хариуцлага хүлээнэ.

34. Үйлдвэрт кран, цахилгаан шат, хий шингэнтэй сав ба дамжуулах хоолой, хий, компрессор зэргийг ашиглахдаа холбогдох дүрэм, журам, стандартыг баримтална.

35. Нэг буюу хэд хэдэн тоног төхөөрөмж ажилладаг ажлын байранд ээлж хүлээлцэх бүртгэлтэй байх бөгөөд уг бүртгэлийн хөтлөлтийг холбогдох албан тушаалтан тогтмол хугацаанд шалгадаг байна.

36. Үйлдвэрийн цех, тасаг, хэсэг нь хоорондоо холбогдох холбооны хэрэгсэлтэй байна.

37. Ажлын байрны аюул, учирч болзошгүй газарт автомат дуут болон гэрлэн дохиоллын системээр тоноглогдсон байна.

38. Үйлдвэрийн шал нь (том савнууд ба тоног төхөөрөмжүүдийн доор) уусмал болон булингыг хуримтлуулах суваг шуудуу, зумпф рүү налуу байна.

39. Зумпф нь насос бүхий тосгуур сувгаас бүрдэх ба урсцыг цуглуулж технологийн процессод эргүүлэн ашиглах нөхцөлийг хангана. Урсцыг саармагжуулахгүйгээр гадагш хаяхыг хориглоно.

40. Баяжуулах, боловсруулах үйлдвэр болон хаягдлын аж ахуйг суурьшлын бүсэд байгуулахыг хориглоно.

41. Баяжуулах, боловсруулах үйлдвэрт зөвшөөрөлгүй хүн нэвтрүүлэхийг хориглоно.

Бүлэг - II Аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага

2.1. Эрүүл ахуйн шаардлага

42. Үйлдвэрийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангасан нөхцөл бий болгохын тулд дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- а. Үйлдвэрийн зураг төслийг зохиоход агааржуулах, ба–шүүх төхөөрөмжийг эрүүл ахуйн стандартад нийцүүлэн байрлуулах, мөн хортой хий хуримтлагдаж болох газарт автомат мэдрэгч эсвэл хэмжигч байрлуулахаар төлөвлөх;
 - б. Бүх агааржуулах ба шүүх төхөөрөмжийн ашиглалт, засварлалт, мөн агаарын чанарыг хянах ажлыг зохион байгуулах;
 - в. Бутлах, хатаах, урвалжийн хэсэг, тээвэрлэлт болон бусад хэсэг мөн гидрометаллурги, шаталтын процессоос үүсэх тоос, хийн ялгаралтыг багасгах арга хэмжээ авах.
43. Тоос хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх, цэвэрлэх ажлыг хөнгөвчлөхийн тулд үйлдвэрийн барилга, байгууламжийн хана гялгар гадаргуутай байна. Тоос цэвэрлэх ажиллагааг механикжуулсан (усаар угаах буюу хийн цэвэрлэгээ) байна.
44. Нойтон цэвэрлэгээ ба угаалга хийдэг цех, тасгийн шал нь ус нэвтрэхгүй байна. Ус урсахад зориулагдсан шалны налуу нь 0.02 (1.8⁰)-аас багагүй байна. Үндсэн явган замын шалны налуу 0.04 (2.6⁰)-аас ихгүй байна.
45. Үйлдвэр болгон захиргаа, аж ахуйн байртай байх бөгөөд тэдгээр нь “Барилгын норм ба дүрмүүд”-ийн шаардлагын дагуу баригдсан байна.
46. Хүлээн авах бункерыг суллах үед тоосжсон агаар үйлдвэрийн байруудад орохоос хамгаалахын тулд, тэнд зохих хэмжээний материалыг үлдээх хэрэгтэй.
47. Ажиллах үедээ тоос ялгаруулдаг тоног төхөөрөмж (бутлуур, шигшүүр гэх мэт)-д битүү бүрхүүл хийж, тусгай сорох хоолой гарган шүүх төхөөрөмжид холбосон байна.
48. Ажлын байранд байгаа тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн шугамын гадаргуугийн температур нь 45°C-аас дээш байх үед тусгаарласан байна.
49. Агааржуулах байгууламж нь шаардлагатай тохиолдолд хоолойгоор урсах агаарын хурд, даралт, температур, эзлэхүүнийг хянах, хэмжихэд зориулсан багаж хэрэгслээр тоноглогдсон байна.
50. Тоос дарах болон цуглуулах систем бүхий үндсэн ба туслах тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө уг системийг эхлээд ажиллуулна.
51. Агааржуулах, шүүх хэрэгслээр агаарыг агаар мандалд гаргахын өмнө түүнд байгаа тоосны хуримтлалыг зөвшөөрөгдсөн хэмжээнд хүртэл цэвэрлэнэ. Цэвэрлэх багаж хэрэгслийг тоосны физик, химийн шинжийг үндэслэн сонгоно.
52. Шүүх системээр агаарыг байрнаас гаргахад түүнийг нөхөхийн тулд гаргасан агаартай тэнцүү хэмжээтэй буюу илүү хэмжээтэй агаар зохиомлоор урсан орж байх зүй тогтлыг баримтална. Өгөх агаарыг шүүлтүүрээр цэвэрлэх ба өвлийн цагт халаагуураар халаасан байна.
53. Өгөх агаар сорж авах байрыг сонгон авахдаа агаарын бохирдолт бий болох эх үүсвэр ба салхины зонхилох чиглэлийг харгалзан үзсэн байна.

54. Үйлдвэрлэлийн орчны доргио, шуугиан нь холбогдох стандартад заасан хэмжээнээс хэтрэхгүй байна. Эрүүл ахуйн шаардлагын хэмжээнээс илүү доргио, шуугиантай байгаа газарт ажилтныг дуу чимээнээс тусгаарласан кабин хэрэгслээр хангах буюу бусад арга хэмжээг авч, дуу чимээг эрүүл ахуйн шаардлагад хүргэнэ.

55. Цонхны шил засварлах, цэвэрлэх, мөн агааржуулах нээлхий, гэрлийн арматур зэрэгт үйлчилгээ хийхэд тусгай байгууламж, төхөөрөмж (ажлын тавцан, сагстай өргөгч, дүүжин шат гэх мэт) ашиглана.

56. Мод хадгалах газар, шатамхай ба өөрөө шатах чулуулаг болон хүдрийн овоолгыг үйлдвэрээс 100 м-ээс багагүй зайд байрлуулахыг хориглоно. Мод хадгалах газар ба мөн дээр дурдсан овоолгыг зонхилох салхины чиглэлийг харгалзан байрлуулна.

2.2. Аюулгүй ажиллагаа

2.2.1. Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохио, хаалт хашилт

57. Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохионд “Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө” стандартыг баримтлана.

58. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг угсрах, засвар үйлчилгээ хийх, хадгалах, зөөж тээвэрлэх, ашиглахдаа “Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа” стандартыг баримтлана.

59. Аюул бүхий талбайд байрлуулах хаалт, хашилтад тавигдах журмыг байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, мөрдөж ажиллана.

2.2.2. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл

60. Ажилтны үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлээс ажилтныг хамгаалах буюу түүний нөлөөллийг бууруулах зорилгоор “Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл” стандартыг баримтлана.

2.2.3. Галын аюулгүй байдал

61. Үйлдвэр нь “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм” болон холбогдох журам, заавар, стандартыг баримтална.

62. Амархан гал авалцах ба шатамхай бодис агуулсан агуулах, цех, үйлдвэрийг барих буюу тоноглохдоо энэхүү дүрэм болон “Барилгын норм ба дүрмүүд”-ийн галын аюултай байдлын ангиллыг баримтална.

63. Шатах тослох ба арчих материалуудыг ажлын байранд хадгалахдаа нэг хоногт шаардагдах хэмжээнээс ихгүй материал төрөл бүрээр нь тагтай төмөр саванд хадгална. Амархан гал авалцах (бензин, керосин, бусад төрлийн) бодисыг ажлын байранд хадгалахыг хориглоно.

64. Үйлдвэр нь тухайн орон нутгийн онцгой байдлын алба болон ойролцоо хүн ам суурьшсан газартай шууд холбогдох холбооны хэрэгсэлтэй байна.

65. Үйлдвэрлэлийн зориулалттай зам нь галын машин явахад тохиромжтой байна. Хэрвээ үйлдвэрлэлийн нөхцөлөөс болоод орох, гарах замгүй барилга, байгууламж байвал, гал унтраах тээврийн хэрэгсэлд зориулж, уг барилга, байгууламжийн дагуу хоёр талаараа 6 метрээс багагүй өргөнтэй талбайг засаж тэгшилсэн байна.

66. Зам буюу зассан талбайн захаас барилгын хана хүртэлх зай нь 25 метрээс ихгүй байна. Гал унтраах тээврийн хэрэгсэлд зориулж зассан талбай нь цэвэрхэн, гаднын янз бүрийн юмс байхгүй, ус зайлуулах сувагтай байхаас гадна нунтаг наангилаг хөрстэй бол зүлэг суулгах буюу хөрсийг хайрга, дайргаар хучсан байна.

67. Үйлдвэрийн үндсэн ба туслах бүх байр, байгууламж, тоног төхөөрөмж, агуулах нь гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, нормын дагуу тоноглогдсон байна. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн тоо, байршлыг Онцгой байдлын албатай зөвшилцөн сонгоно.

68. Үйлдвэрийн талбай нь галын аюулаас хамгаалах усан хоолойтой байх ба галын гидрант нь зам, гаталга замын дагуу өөр хооронд нь 150 метрээс холгүй, барилгын хананаас 5 метрээс багагүй зайтай, замын уулзвараас 2 метрээс холгүй байрлана.

2.2.4. Цахилгааны аюулгүй байдал

69. Үйлдвэрийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, техникийн баримт бичгийн хөтлөлтийг “Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм”, “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

70. Барилга байгууламж нь “Барилга байгууламжийн аянгын хамгаалалтын зохион байгуулалт, зураг төсөл зохиох заавар”-ын дагуу аянгын хамгаалалтаар тоноглогдсон байна. Аянга зайлуулагч, газардуулагчийн урсгалын эсэргүүцлийн бүрэн бүтэн байдлын үзлэг, шалгалт хэмжилтийг аянгын улирал эхлэхийн өмнө хийж, үр дүнг бичиж тэмдэглэнэ.

71. Цахилгаан механикийн тоног төхөөрөмжийг засварлах ажлыг байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

2.2.5. Аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ

72. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох зааврын дагуу боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдөж ажиллана.

2.2.6. Ажлын байрны үзлэг шалгалт

73. Ажлын байрны үзлэг шалгалтыг холбогдох хууль эрхзүйн актуудыг удирдлага болгон боловсруулсан дотоод дүрэм, зааврын дагуу гүйцэтгэнэ.

2.2.7. Засвар, угсралт, үйлчилгээний болон зөөврийн ажил

74. Аливаа засвар, угсралт, үйлчилгээ, зөөврийн ажлыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу эрсдэлгүй гүйцэтгэнэ.

75. Өндөр даралтын төхөөрөмжийг ашиглахдаа “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, өргөх механизмыг ашиглахдаа “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг баримтлана.

76. Өндөрт ажиллах, хязгаарлагдмал орчинд ажиллах, өндөр хэмийн ажлууд болон гар ажиллагаатай багаж хэрэгсэлтэй ажиллах үед байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан аюулгүй ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ.

Тайлбар: Өндөр хэмийн ажлууд гэдэг нь ажлын талбай, үйлдвэр, тоног төхөөрөмж, сав, шугам хоолойн ойролцоо галын эх үүсвэр болох боломжтой бүх төрлийн ажлыг хэлнэ. Галын эх үүсвэр гэдэг нь агаар ба түлш, тэсрэмтгий агаарын найрлага бүхий орчимд гал эсвэл тэсрэлт үүсэх боломжтой энергийн эх үүсвэр юм.

2.2.7.1. Тоног төхөөрөмжийн тусгаарлалт

77. Үйлдвэр нь тусгаарлалтын журамтай байх бөгөөд түүнийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана. Энэхүү журамд тусгаарлалтын ангилал, төрөл, цоож пайзны систем гэх мэт бусад шаардлагатай асуудлыг тусгасан байна.

Тайлбар: Тусгаарлалт гэдэг нь аюултай гэж тогтоогдсон энергийн бүх эх үүсвэрийн хяналт юм. Энергийн бүхий л төрлийг авч үзэх шаардлагатай. Үүнд: Цахилгааны, хийн, шингэний, таталцлын, хуримтлагдсан (пүрш, батарей), потенциал (байршлын улмаас), дулааны (халуун усны, уурын), цацраг идэвхт эх үүсвэр, хортой, идэмхий, шатамхай чанартай гэмтэл ба өвчлөл учруулж болохуйц хий, ууршилт, шингэн, тоосонцор зэрэг аюултай бодисууд багтана.

78. Тоног төхөөрөмж дээр засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэхийн өмнө тоног төхөөрөмжийг аливаа энергийн эх үүсвэрээс тусгаарлана. Дараах үндсэн зарчмуудад суурилсан байна. Үүнд:

- а. Ажил эхлэхээс өмнө бүх аюултай байж болзошгүй энергийн эх үүсвэрийг тусгаарласан байх;
- б. Систем, үйлдвэрлэл эсвэл тоног төхөөрөмжийг хэрхэн яаж аюулгүй болгох болон аюулгүй байлгахыг тодорхойлох журамтай байх;
- в. Цоожилсны дараа тухайн системийн тусгаарлалт болон энергигүй болгох үйл ажиллагаа амжилттай болсныг баталгаажуулахын тулд системийг энергижүүлэх оролдлого хийж, шалгах аргачлалтай байх;
- г. Зөвхөн ур чадвар эзэмшсэн, эрх бүхий хүн тусгаарлалтыг гүйцэтгэх;
- д. Ажилтан хувийн цоожоо зүүлгүйгээр тусгаарлагдсан тоног төхөөрөмж дээр ажиллахгүй;
- е. Хувийн цоожийг зөвхөн эзэмшигч нь тайлах;
- ё. Эзэнгүй цоожийг эвдэх журмын дагуу эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хувийн цоожийг эвдэж авах.

2.2.7.2. Тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэг

79. Үйлдвэр, түүний цех, хэсэг нь тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална.

80. Өргөх, зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү жинтэй тоног төхөөрөмж, эд ангийг зөөвөрлөхөд өргөх, тээвэрлэх хэрэгсэл ашиглана. Өргөх, тээвэрлэх хэрэгслийн даац нь хамгийн хүнд жинтэй эд анги, эсвэл машины нийт жинтэй тохирч байна.

81. Хүнд болон овор ихтэй зангилаа эд ангийг өргөж зөөвөрлөх ажлыг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийн дагуу томилогдсон ажилтан удирдан гүйцэтгэнэ.

82. Эд анги боодлыг өргөх механизмын татлагаар ташуу татаж газар, шал, рельс гэх мэт дээгүүр чирэхийг хориглоно.

83. Зөөврийн ажил гүйцэтгэх дохиог оосорлогчийн мэргэжил бүхий нэг хүн краны машинчид өгнө. Хэд хэдэн хүн зэрэгцэн дохио өгөхийг хориглоно.

84. Гэмтэлтэй болон техникийн туршилтын гэрчилгээний хугацаа нь хэтэрсэн өргөх тээвэрлэх механизм, хэрэгсэл дээр ажиллахыг хориглоно.

85. Аливаа засварын үйл ажиллагааг эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийг бүрэн зогсоож тусгаарлалтын журмын дагуу холбогдох арга хэмжээг авна.

86. Зайлшгүй тохиолдолд аюул эрсдэлийг бүрэн хянасны үндсэн дээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тусгаарлалт хийгдээгүй тоног төхөөрөмж дээр засвар үйлчилгээ, тохируулга, үзлэг шалгалт хийж болно.

87. Тоног төхөөрөмжийн механик болон цахилгааны хэсгийг зэрэг засварлах үед уг ажлын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулсан байна.

2.2.7.3. Засварын ажил

88. Засвар угсралтын талбайн хэмжээ нь машин механизмын томоохон хэмжээний зангилаа, эд анги, засварын ажилд шаардлагатай багаж хэрэгсэл, материалыг байрлуулахад хангалттай байна. Засвар угсралтын талбайд машины зангилгаа, эд ангийг байрлуулахдаа тэдгээрийн хооронд засвар үйлчилгээ хийх зай үлдээсэн байна. Талбайд байрласан ачаа нь хэт овоороогүй бөгөөд жингээрээ талбайн даацад тохирч байна.

89. Тавцан ашиглаж хийх ажилд, барилга угсралтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу бат бөх хийсэн тавцанг хэрэглэнэ. Энэ зорилгоор тохиолдлын зүйлийг тулгуур болгон ашиглахыг хориглоно.

90. 1.5 метрээс дээш өндөрт тавцан байрлуулах боломжгүй тохиолдолд шат тавьж ажиллах бөгөөд ажилтан хамгаалах бүс хэрэглэнэ. Өндөрт ажиллах үед хамгаалах бүс бэхлэх цэгийг ажлын даалгаварт зааж бичнэ.

91. Зохих хамгаалах байгууламжгүйгээр босоо чиглэлд 2 болон түүнээс олон түвшинд засварын ажил нэгэн зэрэг явуулахыг хориглоно.

92. Засварын ажлыг хөнгөвчлөхийн тулд хүнд жинтэй тоног төхөөрөмжийг задлаж салгах, өргөхөд зориулсан тусгай тоноглолыг байрлуулах арга хэмжээ авна. Засварын талбайн орчинд засварын ажлыг хөнгөвчлөхөд зориулсан блок буюу дээврийн элементүүдийг хүч нэмэгдүүлсэн байна. Барилгын хийцийн бат бэхийг шалгахгүйгээр татанги, дам нуруу болон бусад хийцэд түр ашиглах тоноглол дүүжлэхийг хориглоно.
93. Үйлдвэрийн ажиллаж буй цех, хэсэгт засвар, угсралтын ажил гүйцэтгэх үед засварын ажлын удирдагч нь уг цех, хэсгийн удирдлагатай хамтран ажиллагаанд үлдэж буй тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, засварын ажлыг аюулгүйгээр гүйцэтгэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. Хэрэв засварын ажлыг туслан гүйцэтгэгч байгууллага гүйцэтгэж байгаа бол ажил зохион байгуулахаар урьдчилан боловсруулсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.
94. Галын аюултай байранд ил гал гарах засварын ажил хийх шаардлагатай бол тогтоосон журмын дагуу бичгээр үйлдсэн ажлын тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
95. Бутлуур засварын ажлын үед хүмүүсийг дээш гаргах, доош буулгахад зориулан зөөврийн шат хэрэглэнэ. Бутлуурын ажлын бүсэд хүмүүсийг хамгаалах бүс буюу аюулаас хамгаалах татлагагүй оруулахыг хориглоно.
96. Эргэлдүүрт (алхан ба нударган бутлуур, цохиж ойлгох бутлуур, хүрдэн шигшүүр гэх мэт) тоног төхөөрөмжийн дотор орж ямар нэгэн ажил гүйцэтгэхийг зөвхөн тэдгээр тоног төхөөрөмжийн их биеийн (арьс) сөхсөн таг өөрөө бууж хаагдах боломжгүйгээр найдвартай бэхэлж, тусгаарлалтын журмын дагуу холбогдох арга хэмжээг хангасан нөхцөлд зөвшөөрнө.
97. Туузан дамжуургын туузыг солих, залгах, элеваторын гинжийг засварлах ажилд зохих хэмжээний даац бүхий чангаах өргөх хэрэгсэл хэрэглэнэ.
98. Туузан дамжуургын туузыг халааж наахдаа үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажлын стандарт журам, заавар боловсруулан мөрдөж ажиллана.
99. Бункерын хуягийг солих буюу засварлах үед түүний налуу хананд аюулгүй ажиллагааг хангаж чадах тоноглол хэрэгслийг ашиглана.
100. Засварын ажил явагдаж байгаа бункерт ачаа буулгахыг хориглоно. Засвар хийж буй хэсгийн дээр байрласан материал буулгах амсрыг засварын ажил аюулгүй явуулахад хүрэлцэхүйц уртын хэмжээнд найдвартай тагласан байна.
101. Тээрэм дотор хүмүүс байх үед тээрмийг эргүүлэх болон тээрэмд шинэ хуяг тавихын тулд хуучин хуягийн боолтыг аюулгүй ажиллагааг бүрэн хангаагүй үед дотогш цохиж суллахыг хориглоно. Тээрмийн хуучин хуягийг өөрөө сугарч унахааргүй байрлалд тохируулж боолтыг авна.
102. Тээрэм дотор хуягийг зөөх, байрлуулахад зориулсан тусгай төхөөрөмж байхгүй бол зохих зааварчилга авсан ажилтан уг ажлыг гүйцэтгэнэ. Тээрмийн хуягийг солих үед тээрэм өөрөө эргэхээс хамгаалсан төхөөрөмжөөр тоноглогосон байна. Нунтаглах биетийг

гаргалгүйгээр тээрмийн хуягийг солих бол тээрэм дотор хүн явах шал дэвсэж, уг нөхцөл байдалд тохируулан боловсруулсан аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан ажиллана.

103. Тээрмийн дотор хуяг зүсэх, огтлох, гагнах ажил хийх явцад гагнуурын аппарат, хийн баллоныг тээрмийн дотор болон аман дээр байрлуулахыг хориглоно. Мөн агаарын найрлага зөвшөөрөгдөхүйц хэмжээнд байхаар агааржуулалттай байна.

104. Хорт урвалжтай (цианид г.м) орчинд ажилладаг тоног төхөөрөмжийг засварын өмнө урвалжаас сайтар цэвэрлэж, саармагжуулж, хоргүй болгосон байна.

105. Хийн зөөлөн хоолой, хийн багаж, төхөөрөмжүүдийг шахсан агаарын эх үүсвэрээс бүрэн хаасны дараа залгах эсвэл салгана.

106. Түшүүргэн шатан дээр механикжсан багаж хэрэгслээр ажиллахыг хориглоно.

107. Хасуур болон бусад металл огтлох, цавчих, цэвэрлэх гар багаж хэрэгслээр ажиллах үед ажилтныг хамгаалалтын тусгай нүдний шил шаардлагатай тохиолдолд хамгаалах дэлгэцээр хангасан байна.

2.2.7.4. Хийн ил дөлтэй ажил

108. Хийн ил дөлтэй ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу үйлдвэрийн эрх бүхий удирдах ажилтны баталсан заавраар гүйцэтгэнэ.

109. Гал авалцаж амархан шатдаг материалыг (тос, арчих материал г.м) гагнуур хийж буй байрнаас 10 метрээс багагүй зайд зайлуулсан байна.

110. Гагнуур хийх үед барилга байгууламжийн модон болон бусад шатдаг хэсгийг гагнуур хийж буй байршлаас 2 метр хүртэл зайд галд тэсвэртэй, хавтгай төмрөөр хамгаалсан байна.

111. Гагнуур хийж буй газарт галын хор, галын гидрант хоолой, 1 тонноос доошгүй устай торх болон элстэй хайрцаг байвал зохино.

112. Хүнд жинтэй, овор ихтэй эд ангийг хялбар хөдөлгөж эргүүлэхэд тохиромжтой өргөх хэрэгсэл, зориулалтын тавцан ашиглаж гагнана.

113. Гагнуурын ажилд оролцож байгаа бүх ажилтан хамгаалалтын нүдний шил хэрэглэнэ.

114. Гагнуурын ажлын байранд керосин, бензин бусад хялбар шатах бодис хадгалахыг хориглоно.

115. Засварын ажлыг аюулгүй гүйцэтгэх арга хэмжээг зааж, баяжуулах үйлдвэрийн эрх бүхий удирдах ажилтны баталсан технологийн карт буюу ажлын стандарт журам, зааврын дагуу гүйцэтгэнэ. Технологийн карт буюу ажлын стандарт журам, заавар байхгүй тохиолдолд засварын ажлыг аюулгүй ажиллагааны арга хэмжээг бүрэн зааж, бичгээр үйлдсэн ажлын тусгай зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ.

116. Засварын ажлын үед аюултай бүсүүдэд хаалт, хамгаалалт тавьж анхааруулах тэмдэг тэмдэглэгээ тавьж өлгөнө.

117. Шатах шингэн, хийгээр зүсэх ажил гүйцэтгэхэд хошууг хүчилтөрөгчийн шлангийг буцаах цохилтоос хамгаалах үл буцаах хавхлаг (клапан)-аар тоноглогсон байна.

118. Хатаах тоног төхөөрөмжид (хатаах хүрд, цахилгаан зуух гэх мэт) засвар хийхдээ үлээх төхөөрөмжийг бүрэн зогсоож, дулаан үүсгэгчийн өгөлтийг таслаад, хорт хийн үлдэгдлийг шавхаж, засвар хийх хэсгийн температур 40°C-аас доош буусан үед гүйцэтгэнэ.

119. Тоног төхөөрөмжийн хөдлөх эд анги нь хаалт хамгаалалттай байна. Хөдлөх хэсгийн хаалт нь бат бөх бэхлэгдсэн байна.

120. Тоног төхөөрөмжийн эргэх эд анги (гол, муфт, дамар, хүрд г.м) нь битүү буюу 25x25 мм-ээс ихгүй хэмжээтэй торон хаалттай байна. Конвейерийн хүрдний торон хаалт нь 40x40 мм-ээс ихгүй хэмжээтэй байна. Шүдэт ба араат дамжуулага нь түүний өндөр, хөдөлгөөний хурдаас үл хамааран битүү халхавчтай байна.

121. Тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө анхааруулах дохио өгнө. Хэрвээ уг тоног төхөөрөмж нүдэнд үл харагдах газар байвал 10 сек-ээс багагүй хугацаагаар дуут дохио өгнө. Анхны дохио өгсний дараа 30 сек-ээс багагүй хугацаа өнгөрсний дараа хоёр дахь дохиог 30 сек-ээс багагүй хугацаанд өгнө. Тоног төхөөрөмжийг ажиллуулахад заасан хугацааг бүрэн тусгасан хориг хийгдсэн байна. Тоног төхөөрөмжийг ажиллуулах дохиог холбоогоор (радио холбоо, чанга яригч г.м) өгч уг тоног төхөөрөмжийн ашиглалтын дугаар ба нэрийг тодорхой хэлнэ. Дуу чимээ ихтэй газар дуут дохионоос гадна гэрлэн дохио хамт хэрэглэнэ. Тоног төхөөрөмжийг ажиллуулах дохионы журамтай үйлдвэрийн бүх ажилтан танилцсан байна. Тоног төхөөрөмж ажиллах үед үйлчлэх ажилчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

122. Тоног төхөөрөмжийн угсралт, засварын ажлыг хийхдээ цоож, пайзны журмыг баримтална. Угсралт, засварын дараа тоног төхөөрөмжийг ажиллуулахаас өмнө уг тоног төхөөрөмжийн аюултай бүсэд хүн ба гаднын эд юмс байгаа эсэхийг заавал шалгана. Тоног төхөөрөмжийг угсралт, засварын дараа тухайн ажлыг хариуцаж гүйцэтгэсэн албан тушаалтны хяналтын дор ажиллуулна.

123. Тоног төхөөрөмж ажиллаж байгаа үед түүний хөдлөх хэсэг болон хаалт хамгаалалтыг засварлах, асгарсан хаягдлыг гараар цэвэрлэх мөн түүнчлэн тусгай хэрэгсэл багажгүйгээр ажиллаж буй тоног төхөөрөмжид гараар тослогоо хийхийг хориглоно.

124. Тоног төхөөрөмж ажиллаж байхад гэнэт цахилгаан тасрах эсвэл өөр шалтгаанаар зогссон үед өөрөө ажиллахаас сэргийлж, уг тоног төхөөрөмжийн бүх цахилгаан хөдөлгүүрийг хүчдэлээс салгах автомат унтраагуур заавал байна.

125. Зураг төсөлд тусгагдаагүй тоног төхөөрөмж, хэрэгслийг угсрах, ашиглах ажлыг эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

126. Тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа паспорт, технологийн карт буюу тусгай заавраар тогтоогдсон техникийн горимыг баримтлан ажиллуулна.

127. Ашиглагдаж байгаа бүх төрлийн тоног төхөөрөмж, багаж тусгай хэрэгсэл нь бүрэн бүтэн байна. Тэдгээрт хийгдэх үзлэг, үечилсэн шалгалт туршилтууд нь зохих заавар, ашиглалтын дүрмийн дагуу хийгдэнэ. Эвдэрсэн багаж хэрэгсэл хэрэглэх, гэмтэлтэй тоног төхөөрөмж дээр ажиллахыг хориглоно.

2.2.8. Тоос (тоос барих систем), хий цэвэрлэх систем

128. Үйлдвэрийн тогтмол тоос үүсгэдэг тоног төхөөрөмж бүр дээр тоос цуглуулах төхөөрөмжийг тоногловсон байна.

2.2.9. Агааржуулалт

129. Үйлдвэрийн байр нь агаар сэлгэх системтэй байна. “Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер” барилгын норм ба дүрэм 410111-ийг баримтлана.

130. Хүмүүс байнга ажилладаг үйлдвэрлэлийн бүх ажлын байранд агаарын бохирдолтын хэмжээг харгалзахгүйгээр зохиомол агааржуулалт хийнэ. Үйлдвэрийн цех, хэсэг, агуулах болон бусад байранд агааржуулалтыг зураг төслийн дагуу хийнэ.

131. Шинээр угсарсан ба сэлбэн шинэчилсэн агааржуулах тоног төхөөрөмжийг үйлдвэрийн удирдлагаас томилогдсон комисс ашиглалтад хүлээн авна.

132. Агааржуулах тоног төхөөрөмж гүйцэд хийгдээгүй, доголдолтой ажиллаж байх үед ашиглалтад хүлээн авахыг хориглоно. Үйлдвэрийн хэсэг бүрт агааржуулагч тоног төхөөрөмжийг ашиглах, арчлах ажлыг үйлдвэрийн удирдлагаас баталсан тусгай зааврыг баримтлан гүйцэтгэнэ.

133. Үйлдвэр ажиллаж байх үед агаар сэлгэлтийн бүх систем тасралтгүй ажиллана. Хэрэв түр хугацаанд зогсоох бол зөвхөн үйлдвэрийн эрх бүхий ажилтан зөвшөөрөл олгоно. Агааржуулах систем гэмтэлтэй үед тоос ба хий ялгардаг технологийн тоног төхөөрөмж ажиллуулахыг хориглоно.

134. Өндөр эрсдэлтэй ажлыг ажлын тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

135. Агаар дахь тоосны хэмжээ, температур, чийглэг, хурдыг тодорхойлох зорилгоор ажлын байранд улиралд нэгээс доошгүй удаа мөн технологийн горим өөрчлөгдөх, агааржуулах, шүүх тоног төхөөрөмжийн сэлбэн шинэчлэлт, их засварын дараа агаарын сорьцыг тогтмол авч тодорхойлно. Агаарын сорьц авах цэгүүдийг үйлдвэрийн холбогдох албан тушаалтны баталсан төлөвлөгөөний дагуу тогтооно.

136. Ажлын байрыг зохих нормын дагуу гэрэлтүүлсэн байх ёстой. Цех, тасгуудад байх аваарын гэрэлтүүлэг нь ерөнхий тэжээгчээс үл хамаарах (бие даасан тусгай тэжээгчтэй) бөгөөд БН ба Д-ийн (Барилгын норм ба дүрэм) шаардлагыг хангаж байна. Тогтмол хэрэглэгдэх гэрэлтүүлэг нь зөвхөн цахилгаанаар ажиллана. Үйлдвэр, урвалжийн агуулах болон бусад байрнуудын гэрэлтүүлэг нь үйлдвэрийн байрны шаардагдах байгалийн болон хиймэл (цахилгаан) гэрэлтүүлгийн нормд тохирсон байна. Үйлдвэрт аваарын гэрэлтүүлэг байхгүй тохиолдолд ажлын байруудад аккумулятороор ажилладаг гэрэлтүүлэгтэй байна.

137. Үйлдвэр нь хор аюулын лавлахтай байх бөгөөд урвалжтай харьцаж ажилладаг ажилтан нь уг лавлахтай танилцсан байна.
138. Урвалжтай ажиллах, түүнийг хадгалах байран дахь хортой бодисын дэгдэлт, ууршилтын хэмжээг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах агааржуулах төхөөрөмж ажиллуулна.
139. Урвалжтай харьцаж ажиллах, мөн түүнчлэн тоног төхөөрөмжүүдийг цэвэрлэх, засварлах зэрэг төрөл бүрийн ажлыг шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл бүхий 2-оос доошгүй ажилтан хийж гүйцэтгэнэ.
140. Урвалжтай ажиллаж харьцахдаа тэдгээрийг хөрс, шал, тоног төхөөрөмж, сав суулга, хувцас болон биен дээрээ асгах, цалгиулах бударгахгүй байх урьдчилсан арга хэмжээг авсан байна. Шалан дээр болон тоног төхөөрөмж дээр асгарч савирсан урвалжийг зааврын дагуу цэвэрлэж, саармагжуулж, усаар сайтар угаасан байна. Урвалжийг ачих, буулгах ба хадгалах байранд асгарч савирсан урвалжийг цэвэрлэхэд зориулагдсан хэрэгсэл хүрэлцэхүйц хэмжээтэй байна.
141. Урвалжтай ажиллаж харьцдаг ба тэдгээрийг хадгалдаг байранд тамхи татах, хооллох, мөн түүнчлэн урвалжтай харьцаж ажилласны дараа гараа угааж, цэвэрлэхгүйгээр хоол хүнсний зүйл барихыг хориглоно.
142. Урвалжийн хэсэгт бие махбод, арьсан дээр дуссан хүчил, шүлтийг хурдан хугацаанд их хэмжээний усаар угааж арилгахад зориулагдсан дарж онгойлгодог кранттай бударгах хошуу бүхий нарийн зөөлөн хоолойтой (шаланг) төхөөрөмж болон нүд угаахад зориулагдсан ундны усны оргилууртай адил цорго байрлуулсан байна. Эдгээрийг нь зөвхөн шууд зориулалтаар нь хэрэглэнэ.
143. Урвалж хэрэглэдэг цех, хэсэгт боолтын материал, төрөл бүрийн хорын эсрэг үйлчилгээтэй бодис, түлэгдэлтэд түрхэх эм бүхий эмийн сангаар тоноглогдсон тусгай өрөө байна. Хорын эсрэг үйлчилгээтэй эмийг бусад эм боолтын материалаас салангид, хаяг бүхий шүүгээнд хийж лацадна. Нүдэнд харагдахуйц газар түлэгдэх ба хордоход үзүүлэх анхны тусламжийн заавар, мөн түүнчлэн хорын эсрэг үйлчилгээ бүхий эмийг хэрэглэх жор, хадгалах нөхцөл зэргийг бичиж, байрлуулна.
144. Урвалжтай ажиллаж харьцдаг ажилтан бүр ажлын дараа заавал усанд орно.
145. Агааржуулалтын систем зогссон эсвэл ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү хэмжээгээр хөнөөлтэй бодис тархсан үед түргэн хугацаанд ажлыг зогсоож, хүмүүсийг цэвэр агаарт яаралтай гаргана.
146. Урвалжтай харьцаж ажилладаг болон хадгалдаг байранд гаднынн хүн орохыг хориглоно.
147. Урвалжийн агуулах, хэсэгт үзлэг цэвэрлэгээ хийх, хоргүй болгох, урвалж дамжуулах хоолой, агааржуулах системийг засварлах, цэвэрлэх зэрэг ажил гүйцэтгэхээр томилогдож байгаа ажилтан, ажлын удирдагчаас урьдчилсан зааварчилга авч, аюулгүй ажиллагааны аргууд, ажлын хэмжээ зэргийг заасан ажлын тусгай зөвшөөрөл авч ажиллана. Ажилтан

урвалжийн саванд орж засвар, үйлчилгээ хийх, үлдсэн урвалжийг цэвэрлэхэд хамгаалалтын бүс, хорт хийн баг болон тусгай хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ.

148. Шахуурга ажиллаж байгаа үед урвалж дамжуулах хоолой, тоног төхөөрөмжийг засахыг хориглоно. Шахалтын дамжуулах хоолойн хаалт, байгууламжийг усан цохилтоос хамгаалахын тулд гэнэт хаах, онгойлгохыг хориглоно.

149. Урвалжийг агуулдаг сав, төрөл бүрийн тоног төхөөрөмжийг цэвэрлэх, засварлах, үзлэг хийхдээ зөвхөн урвалжийг бүрэн султгаж савыг хоргүй болгосны дараа гүйцэтгэнэ.

150. Химийн бодис болон урвалжийг үйлдвэрлэлд ашиглахдаа “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах”-ын стандартыг баримтлан ажиллана.

151. Урвалжтай байранд (урвалж агуулах газар, урвалж бэлтгэх талбар, урвалжийн тасаг гэх мэт) ажилтны хувийн гадуур хувцас, хоол хүнсний зүйл байлгахыг хориглоно. Үйлдвэрт урвалж хадгалах, уусгах, зөөвөрлөх зэрэг, ажлыг үйлдвэрийн эрх бүхий ажилтнаар батлуулсан технологийн картыг баримтлан гүйцэтгэнэ.

152. Урвалжийн хэсэг болон урвалж хадгалах агуулахад ажилладаг бүх ажилтанд зориулж урвалж зөөвөрлөх, бэлтгэх, урвалжийг технологийн процессод хуваарилах мөн анхны тусламж үзүүлэх зэрэг тухайн нөхцөл байдал, хэрэглэж байгаа урвалжид тохирсон зааврыг боловсруулж эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, ажлын байранд бэлэн байлгана.

153. Байрны ерөнхий агааржуулах системээс гадна урвалж буулгах, урвалж агуулсан сав задлах, урвалж уусгах болон тунгаах торх зэрэг хортой бодис ялгардаг ажлын байруудад соруул бүхий төмөр бүрхүүлтэй тусгай агааржуулах төхөөрөмж тавьсан байна.

154. Урвалжийн хэсэг, урвалж хадгалах байрнаас урьдчилан ариутгаж цэвэрлэлгүйгээр хог хаягдал, урсац хаяхыг хориглоно.

155. Хоорондоо нийлж урвалд орж хорт хий (хүхэрт ус төрөгч, циант устөрөгч, мышьякийн устөрөгч зэргээс), эсвэл хоолойг бөглөх, уусдаггүй хатуу бодис үүсгэх, урсцуудыг нийлүүлэхийг хориглоно.

2.2.10. Гэрэлтүүлэг

156. Ажлын байранд “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг” барилгын норм ба дүрэм 230208-ийг баримтлана.

2.2.11. Эргономик, Ажлын талбар, ажлын байрны эмх цэгц,

157. Ажлын байр болон ажил гүйцэтгэх аргыг ажилтанд тохирсон байхаар зөв төлөвлөж зохион байгуулна.

158. Ажлын байрны эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллана.

2.2.12. Дуу, шуугиан

159. Ажлын байранд MNS5002:2000 “Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” стандартыг баримтлана.

Бүлэг - III Баяжуулалт

3.1. Материал хүлээн авалт, бутлалт, нунтаглалт

3.1.1. Хүдрийг зөөвөрлөх, хүлээн авах ба завсрын бункер

160. Хүлээн авах бункер нь хориглох бол “улаан”, зөвшөөрөх бол “ногоон” дохионы гэрлүүдээр тоноглогдсон байна.

161. Хүлээн авах бункерын талбай, анхдагч бутлуурын талбай хоёрын хооронд харилцаа холбооны хэрэгслээр холбогдсон байна.

162. Хүлээн авах бункерт машин гулсаж орохоос хамгаалсан саад тавьсан байна. Өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл ачаагаа бүрэн асгаж, тэвшээ буулгасны дараа хөдөлнө.

163. Материал хүлээн авах төхөөрөмжийн материал буулгах талаас бусад тал нь бат бэх хашлагатай байна. Харин хоёр тийшээ нь буулгадаг бол хоёр хажууг нь хашсан байна.

164. Хүлээн авах бункерийн талбай нь тоос дарах хэрэгслээр тоноглогдсон байна.

165. Ачаа буулгах нээлхий онгорхой байхад хүлээн авах бункерт материал буулгахыг хориглох ба бункерээс ачаа буулгах үед нээлхийн эсрэг талд хүн байхыг хориглоно.

166. Бункерт гацсан материалыг жижиглэх ажлыг тусгайлан гаргасан нүхээр гүйцэтгэнэ. Бункерт материал бөглөрсөн, гацсан байдлыг арилгахын тулд тусгай (цахилгаан доргилуур, хийн шахуурт төхөөрөмж ба бусад) хэрэгсэл хэрэглэнэ. Бункерийн бөглөрөл, гацааг арилгах зорилгоор хүн оруулахыг хориглоно.

167. Хэрэв завсрын бункер өөрөө буулгагч тэргэнцрээр материал асгадаггүй бол таглаж байна. Өөрөө буулгагч тэргэнцэр болон сэлгэх конвейер хэрэглэх бол материал асгах нүхнүүдийг 200 мм-ээс ихгүй нүхтэй сараалжаар таглах эсвэл 1 м-ээс багагүй өндөртэй хашлагатай байна.

168. Бункер ба хүлээн авах байгууламжид үзлэг засвар хийхийн өмнө шаардлагатай бол материалыг суллаж, битүү бол агааржуулсан байна.

169. Бункер буюу хүлээн авах байгууламжид засварын ажил гүйцэтгэхдээ ажлын тусгай зөвшөөрөл ба ажил зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж дараах нөхцөлийг заавал баримтална. Үүнд:

- а. шаардлагатай бол бункерыг материалаас бүрэн цэвэрлэсэн байна.
- б. уг ажил нь байнгын хяналт дор гүйцэтгэгдэнэ.
- в. хүлээн авах ба завсрын бункерын тээвэрлэх байгууламжийн ажлын талбай болон бункерын түгжих механизмын дэргэд бункер дотор ажил хийж байгааг мэдэгдэх анхааруулах тэмдэг тавьсан байна.

- г. бункерт хүн орохоос өмнө материал хүлээн авах ба өгөх, тэжээлийг зогсоож тусгаарлалтын журмын дагуу холбогдох арга хэмжээг авна.
- д. бункерт ажиллаж байгаа баг нь 3-аас доошгүй хүнтэй байх бөгөөд тэдний 2 нь бункерын дээд хэсэгт хамт ажиллана.
- е. засварын ажил гүйцэтгэж байгаа ажилтан нь хамгаалах бүс бүсэлж бат бэх бэхэлгээний цэгээс холбосон байна. Татлага нь ажлын үед хүлхийхгүй байна.
- ё. бункерт ажиллаж байгаа ажилтанд ямар нэгэн аюул тохиолдохоор бол аль болох түргэн гаргана.
- ж. бункер дотор 12 В-оос дээшгүй хүчдэлтэй зөөврийн гэрлийг хэрэглэнэ.

3.1.2. Бутлалт

- 170. Бутлуурын ажилтан бутлалтаас үүсэх материалын хэлтэрхийд өртөхөөргүйгээр хамгаалагдсан байна.
- 171. Бутлуурт материалын том хэсэг тээглэх, гацах үед түүнийг өргөх хэрэгслийн тусламжтайгаар зайлуулна.
- 172. Бутлуурт гацсан материалыг аюулгүй ажиллагааны шаардлага бүрэн хангаагүй тохиолдолд гараар авах, алх, лантуугаар бутлахыг хориглоно.
- 173. Бутлуурын ажлын хөндийд орж ажиллахдаа хамгаалах бүс хэрэглэх ба дээрээс биет унахаас сэргийлэх арга хэмжээг авна.
- 174. Бутлуурт орсон төмрийг огтлохдоо ажлын тусгай зөвшөөрлийн дагуу удирдах ажилтны хяналтын дор гүйцэтгэнэ.
- 175. Бутлуур материалд дарагдан ослын байдалд зогссон тохиолдолд эрсдэлийг үнэлэн төлөвлөгөө боловсруулж эрх бүхий албан тушаалтны зааврын дагуу бутлуурыг хоослох, цэвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 176. Чичиргээт шигшүүр байрласан барилга байгууламж нь шигшүүр ажиллах үед гарах доргилтыг шингээх чадалтай байхаар тооцоолон баригдана.
- 177. Шигшүүр нь шигшигдэж буй материал шидэгдэж гарахаас хамгаалсан хийц, хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна.
- 178. Хүдрийн хэлтэрхий үсрэхээс сэргийлж бутлуурт материал өгөх амсарт:
 - а. конусан бутлуурыг авагддаг битүү төмөр хаалтаар халхална.
 - б. хацар бутлуураас материалын хэсэг үсрэхэд, саад хийсэн 1 метрээс доошгүй өндөртэй саравчтай цулгүй тал бүрхүүлтэй байна.
- 179. Шигшүүрийн асгах гоожуурын материалыг гараар буулгах, хүн орж цэвэрлэгээ хийхдээ энэхүү дүрмийн 322-т заасан заалтыг баримтлан ажиллана.
- 180. Нударган, хэвтээ ба босоо алхан бутлуурт их биеийн тагийг хаагаагүй байхад санамсаргүй ажиллуулахаас сэргийлэн хориг оньс (блокировка) тавьсан байна. Нударган

ба хэвтээ алхан бутлуурын их биений таг нь 50 кг-аас дээш жинтэй бол хааж, нээх ажиллагааг механик аргаар гүйцэтгэнэ.

181. Нунтаг байдалдаа тэсрэх аюултай тоос үүсгэдэг материалыг бутлахдаа тоосны тэсрэлтээс сэргийлэх арга хэмжээ авсан байна.

3.1.2.1. Мышьякийн ангидридийн үйлдвэрлэл, хүхрийн хүдрийг бэлтгэхэд мөрдөх нэмэлт шаардлагууд

182. Тэсрэх болон галын аюултай мөн хортой хий, уур ялгарч болох үйлдвэрлэлийн байр, хүхэрт хий үүсэж болох бутлуурын хэсэгт ослын үед ажиллах сорох төхөөрөмж тавигдсан байна.

183. Алхан бутлуурын ажлын орчимд хүхрийн хүдрийн тоосны дэлбэрэлтээс урьдчилан сэргийлэхийн тулд доорх шаардлагыг хангана. Үүнд:

а. Бутлуурын ажлын бүсэд уур буюу усан мананцар (манан үүсгэгч, цацагч) байнга өгнө.

б. Бутлах хэсгийн агааржуулалтын төмөр хоолой, туузан дамжуурга бүх цахилгаан тоног төхөөрөмж болон металл хийцийг газардуулгын тасралтгүй хэлхээгээр холбох замаар бутлуурт цахилгаан статик цэнэг хуримтлагдахаас хамгаална.

184. Хүхрийн хүдэр буюу тоосонд агуулагдсан хүхрийн шаталтын голомтыг унтраахын тулд халаалттай бутлах хэсэг, конвейерын галерейд (хуурай бутлалтын үед) галын крант бүхий гал эсэргүүцэх усан хоолой, халаалтгүй тасаг, галерейд гал унтраагуур байрлуулна.

185. Алхан бутлуурын хэсэгт, бутлуурын ажлын бүсэд бутлалтаас үүсэх хүхрийн ислээс ажилтныг хамгаалах тусгаарлагч хорт хийн баг олгоно.

186. Хүхрийн хүдэр бутлах дунд шатны бутлуурыг газрын гадаргуугаас доош төвшинд байрлуулахыг хориглоно.

3.1.3. Нунтаглалт ба ангилалт

187. Нунтаглах болон ангилах төхөөрөмжийн удирдлага нь тухайн тоног төхөөрөмжийн ажиллагааг оператораас ажиглаж хянах газар байрласан байна.

188. Тээрэм дотор үзлэг, засвар, үйлчилгээ хийхдээ тусгаарлалтын журмыг дагаж мөрдөх ба түүнийг агааржуулан агаарын найрлага хэвийн үед ажлыг гүйцэтгэнэ.

189. Тээрэм дотор гүйцэтгэх ажлыг эрх бүхий албан тушаалтны хяналтын доор гүйцэтгэх бөгөөд хязгаарлагдмал орон зайд ажиллах журмыг баримтална.

190. Тээрмийн нээлхий доод талд байрласан байхад нээлхийн тагийн боолтыг суллах, чангалахыг хориглоно.

191. Чингэлэгт бөөрөнцөг ачих, өргөх, буулгах үед ачилтын талбайг хааж «Аюултай» гэсэн бичигт тэвхэр зүүж, ажилтан аюулгүй зайд холдсон байна. Чингэлгийн дүүргэлт нь дээд амсраас 100 мм-ээс доош байна.

192. Цахилгаан соронзон өргөгчийн цахилгаан соронзонг залгахыг зөвхөн цахилгаан техникийн мэргэжлийн хүн гүйцэтгэхийг зөвшөөрнө.

193. Бөөрөнцөг тэжээгч, савх ачаалах механизм ашиглах үед аюулгүй ажиллах дарааллыг тусгасан тусгай заавар боловсруулсан байна.

194. Мушгиа ангилуурын үйлчлэх ажлын тавцан нь ангилуурын онгоцны амсраас 600 мм-ээс багагүй доор байрласан байна. Онгоцонд үйлчлэх тавцангийн нөгөө тал нь 1000 мм-ээс багагүй өндөр хаалт, хашлагаар тоноглогдсон байна.

195. Аяган ангилуурыг ашиглах үед сэлүүрийн рам дээр зогсож, механизмд үзлэг тослогоо хийхийг хориглоно.

196. Ангилуурын мушгиа (спираль)-г өргөх ба эргүүлэх механизмуудыг аюулгүй үйлчлэхэд зориулагдсан төмөр хашлага бүхий гүүр (тавцан) тавьсан байна.

3.2. Баяжуулах үйл ажиллагаа

3.2.1. Гравитац (Хүндийн хүч)

197. Хүнд орчинд баяжуулах төхөөрөмж, угаах хүрд, хүндийн хүчний баяжуулалтын бусад тоног төхөөрөмжид үзлэг хийх, засварлах, дотор нь үлдсэн элс, хүдэр, материалаас цэвэрлэхдээ Тусгаарлалтын журам болон хязгаарлагдмал орчинд ажиллах зааврыг баримтлан ажиллана.

198. Баяжуулалтын дамжлагаас гар аргаар сорьц авах үйлдлийг тухайн тоног төхөөрөмжийн зөвхөн тусгай зориулалт бүхий хэсэгт зөвшөөрнө.

199. Хийгээр ажилладаг тунаах төхөөрөмжийн хийн системд үзлэг хийх, засварлахад нүүрний хамгаалалт, нүдний шилгүйгээр ажиллахыг хориглоно.

200. Даралтат хийгээр ажилладаг тоног төхөөрөмжийг ашиглах үед илүүдэл хий гаргах цонх нь төмөр тороор хаагдсан байна.

201. Хөдөлж байгаа тоног төхөөрөмжөөс баяжуулалтын бүтээгдэхүүний сорьцыг гар аргаар авахыг хориглоно.

202. Тунаах төхөөрөмжийн дотор их биеийг засварлах, цэвэрлэх, төхөөрөмжийн шибенийн тор солих буюу засварлах ажлыг элеваторын башмак засварлах, цэвэрлэх ажилтай хослуулж гүйцэтгэхийг хориглоно.

203. Баяжуулах төхөөрөмжид тэжээл өгөх, бүтээгдэхүүн гарах ховил нь 45°-аас дээш налуутай бол материал шидэгдэхээс хамгаалсан тагтай байна.

3.2.1.1. Шороон ордын баяжуулалт

204. Угаагч хэрэгслийн конвейерын туузаас бул чулууг зайлуулахад тусгай тэвш байрлуулсан байна. Туузаас бул чулууг тусгай хэрэгсэлгүйгээр (гогцоо-бариул) зайлуулахыг хориглоно. Бул чулууг овоолох газар хаалт хийгдсэн байна.

205. Угаах хэрэгслийн бункерт асгасан элсийг даралттай усны урсгалаар буюу тусгай хэрэгслээр зайлуулахыг зөвшөөрнө. Бункерээс бул чулууг зайлуулахдаа зөвхөн конвейер

болон тэжээгчийг зогсоосны дараа тусгай төхөөрөмжийн (блок трос ба бусад) тусламжтайгаар гүйцэтгэхийг зөвшөөрнө.

206. Угаах төхөөрөмжийн ажлын байр нь элс үйрүүлэгч, хайргын овоолго, элсийг угаах төхөөрөмж нь сайн харагдах мөн түүнчлэн гидроэлеваторын ойролцоо орших бусад тоног төхөөрөмжийн ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

207. Хүйтний улиралд ажиллах угаах тоног төхөөрөмжийг дулаалахдаа ажилтны аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангах арга хэмжээг авна.

3.2.2. Хөвүүлэн баяжуулалт (Флотац)

208. Шингэн урвалж ба урвалжийн уусмалуудыг дамжуулах сав, түгээх талбай дахь тэжээгчдэд заавал механик аргаар өгнө. Цианид ба хүхэрт натрийг хуурай байдлаар нь хэрэглэх цэгт шууд өгөхийг хориглоно. Бага хэмжээний урвалжийг хөвүүлэх хэсэгт зөвхөн зориулалтын саваар зөөхийг зөвшөөрнө.

209. Урвалжаас сорьц авахдаа механик аргаар гүйцэтгэнэ. Гар ажиллагаагаар урвалжаас сорьц авахад ажилчид 200 мм-ээс доошгүй урт иштэй сорьц авагчийг хэрэглэнэ.

210. Урвалж найруулах ган болон түгээх сав, тэдэнтэй холбоо бүхий төхөөрөмж нь зайлшгүй тохиолдолд урвалжийг бүрэн өөрийн нь урсгалаар суллах ослын сав, хашлагатай байна. Урвалжийн талбайн урсац хөвүүлэх тасгийн урсацын байгууламжаас тусдаа дамжуулах хоолойгоор зайлуулагдана.

211. Хөвүүлэх машины импеллер элсэнд дарагдах, шугам хоолой бөглөрөх зэрэг технологийн доголдлыг арилгах заавартай байна. Камер дахь булингын байдлыг гараараа шалгаж үзэхийг хориглоно.

212. Техник болон технологийн доголдлын үед хөвүүлэх машиныг суллах, угаасан усыг хуримтлуулахад зориулсан тосгуур, зайлуулах суваг, насостой байна.

213. Хийгээр ажилладаг хөвүүлэх машины агаар дамжуулах хоолойг цэвэрлэх, солих үед нүдний хамгаалах шил хэрэглэнэ.

3.2.3. Радиометр, рентген-люминесценц

214. Радиометр, рентген-люминесценцийн аргаар үйл ажиллагаа явуулж байгаа бол “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”-ийг баримтлана.

3.2.4. Соронзон ба цахилгаан арга

215. Соронзон ба цахилгаан соронзон ялгагч ажиллаж байхад соронзон систем руу соронзон шинж чанар бүхий эд зүйлийг ойртуулахыг хориглоно. Цахилгаан соронзон ялгагчийг зогсоохдоо соронзон системийн ороомгоос хүчдэлийг заавал салгана.

216. Хүдрийг хуурайгаар соронзон ба цахилгаан соронзонгоор баяжуулах үед уг соронзон ялгагч нь тоос барих системтэй хоолойгоор холбогдсон битүү бүрхүүлтэй байна.

Тоос цуглуулах систем ажиллаагүй буюу гэмтэлтэй үед ялгагчийг ажиллуулахыг хориглоно.

217. Ялгагч ажиллаж байхад түүний ажиллагаа, ховилын байдлыг хянах, сэтгэх нээлхийнүүд хаалттай байна. Тэжээгчийн ховилоос гараараа зомгол, элдэв зүйлс авахыг хориглоно.

218. Ялгагчийг туузын байрлал, материал татах зай түүний доор янз бүрийн юм хавчуулж тохируулахыг хориглоно.

219. Цахилгаан ялгагч байрлуулсан өрөөнд гадны хүмүүс орохыг хориглоно.

220. Цахилгаан ялгагчийн бүрхүүл тоос, чийг нэвтрүүлэхгүй байна. Ялгагчийн бүрхүүл, нээлхий нь битүүмжлэлгүй бол ажиллуулахыг хориглоно.

221. Ялгагч ажиллаж байх үед ялгагчийн хаалгыг онгойхыг хязгаарласан автомат хоригоор тоногдсон байна.

222. Өндөр хүчдэлийн шугамаас тасалсан ялгагчийн цахилгаан гүйдэл дамжуулж болох эд ангийг үлдэгдэл цэнэггүй болгож, зориулалтын багажаар шалгахаас өмнө тухайн эд ангид хүрэхийг хориглоно.

223. Цахилгаан ялгагчийн хүчдэлийг салгасны дараа нам хүчдэл талын контактыг цэвэрлэх, чангалах, гал хамгаалагчийг солихоос бусад засвар үйлчилгээний ажлыг ганц ажилтан гүйцэтгэхийг хориглоно.

224. Цахилгаан ялгагч төхөөрөмжийн болон шулуутгагч хэрэгслийн операторын ажлын байр нь зориулалт бүхий тусгаарлагчаар тоноглогдсон байна.

Бүлэг - IV Боловсруулалт

4.1. Гидрометаллурги

225. Нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн хаалтыг “Ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн хаалт” стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

226. Реакторын дүүргэлтэд тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн ашиглалтын зааврыг баримтлана.

Тайлбар: Реактор гэдэг нь хими, физик, биологийн зэрэг урвал явагддаг төхөөрөмжийг хэлнэ.

227. Реактороос шингэнийг суллаж, тэжээгч хоолойнуудыг хаагаад хутгуурыг бүрэн гүйцэд зогсоосны дараа реакторын шингэн юүлэх хоолойг цэвэрлэнэ.

228. Реактор ажиллаж байхад түүний таглаа нягт хаагдсан, сайтар бэхлэгдсэн байна.

229. Реакторыг ажиллуулахын өмнө агаар сэлгэх ба сорох ерөнхий системийг залгах шаардлагатай. Ууссан урвалж цацагдах буюу хорт хий ихээр ялгарахаас болгоомжлохын тулд урвалжийн уусмалыг битүү системээр дамжуулна.

230. Сорох систем зогссон буюу эвдэрсэн тохиолдолд реакторт уусмал ба урвалж өгөлтийг яаралтай зогсоож, дамжуулах хоолойн бүх хаалтуудыг хаана. Системийг бүрэн гүйцэд засварлаж ажилд оруулсны дараа ажлаа үргэлжлүүлнэ.
231. Реактороос их хэмжээгээр химийн урвалж цацагдаж агаарын найрлага дахь хорт хийн агууламж зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хорт хийн баг өмсөж, хутгах төхөөрөмж болон тэжээгдэж байгаа тоноглолуудыг салгаж хүмүүсийг яаралтай гаргана. Агаарын найрлага хэвийн болсон үед ажлаа үргэлжлүүлнэ.
232. Реакторт үзлэг хийх, цэвэрлэх, засвар хийхдээ 12В хүртэл хүчдэл бүхий зөөврийн гэрэл ашиглана.
233. Реакторын дотор талыг цэвэрлэх, засварлах ажлыг 2-оос доошгүй ажилтан хязгаарлагдмал орчинд ажиллах зааврыг баримталан гүйцэтгэнэ.
234. Реактор дотор түүхий эд материал, урвалж хийхдээ цацагдсан уусмалаас, ажилтныг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Реакторт өгч буй хатуу материалыг технологийн шаардлагын дагуу урьдчилан зохих хэмжээнд хүртэл нунтагласан байвал зохино. Материал өгөх хоолойд орсон том хэмхдэс материалыг цохиж хагалахыг хориглоно.
235. Таглагдаагүй реактор доторх булингыг халаахыг хориглоно.
236. Ажлын байр хорт хийн агуулга зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарсан үед автоматаар залгагдах дохиоллын системээр (дуут, гэрлэн) тоноглогдсон байна.
237. Ажлын байр нь агааржуулах системээр тоноглогдсон байх ба агааржуулах систем ажиллагаагүй болбол ажилтан нэн даруй байраа орхино. Агаарын найрлага хэвийн болсон үед ажлаа үргэлжлүүлнэ.
238. Хортой урвалж (цианид ба бусад) хэрэглэдэг үйлдвэрийн цех, тасаг, хэсгийн шал, хана, дээвэр, барилгын хийц нь угаахад хялбар, уусмал шингээдэггүй усанд үл норох бүрхүүлтэй, нягт, гөлгөр байна. Ханаар тусгаарлагдаагүй тавцан нь 20 см-ээс багагүй өндөртэй, ус үл нэвтрэх хөвөөтэй байна.
239. Талбай болон давхар хооронд байрлуулсан тоног төхөөрөмжийн доор хаягдал, шүүрлийг доод давхарт байрлуулсан тосгуурт цуглуулах урсцын системтэй байна.
240. Цианжуулалтыг хүчиллэг орчин бүхий нэг байранд явуулахыг хориглоно. Гагцхүү энэ хоёр процесс технологийн нэгдмэл хэлхээг үүсгэж байгаа тохиолдолд зөвшөөрнө. Энэ тохиолдолд урьдчилан сэргийлэх онцгой арга хэмжээнүүдийг авна. (бүх аппаратуудыг вакуумаар ажиллуулах, ажлын орчин дахь агаарын найрлагыг үргэлж хянах гэх мэт.)
241. Технологийн процесс нь хүчиллэг орчинд явагдаг бол үйлдвэрийн бусад цех, тасаг, хэсгээс тусгаарласан урсцын системтэй байна. Хүчиллэг усыг саармагжуулсны дараа технологийн дамжлагад оруулна. Цех, тасаг, хэсгийн шал, хана, барилгын хийцийг хүчилд тэсвэртэй материалаар хийж, хамгаалсан байна.

242. Хий эрчимтэй ялгарч байгаа газар тухайн байрны агаарыг сорох системээр тоноглогдсон байна. Сорох системийг доор дурдсан газарт хийнэ.

- а. нунтаглах хэсгийн нунтаглалт нь цианжуулсан орчинд явагддаг бол тээрмийн материал авах, асгах хоолойд;
- б. баяжмал хатаах хэсгийн хатаах зууханд материал өгөх ба асгах нүхэнд;
- в. цайрын тунадас хатаах хэсгийн хатаах шүүгээний (зуухны) материал өгөх, хаалганд;
- г. урвалжийн хэсгийн хорт урвалж агуулсан савыг онгойлгох ба султгах хоргонд, урвалжийн тэжээгч, ховхлогч ба цуглуулагч ганд;
- д. үйлдвэрлэлийн урсцыг хоргүй болгох хэсгийн хоргүй болгох төхөөрөмжид;
- е. шингээх хэсгийн давирхай ялгаруулах шигшүүр, нялагчид;
- ё. сэргээх (регенерация) хэсгийн сэргээх зэхүүр ба урвалжийн савнуудад;
- ж. Электролизын хэсгийн цахилгаан задлагч ба балжуулсан (цаваг) ватиныг шатаах зууханд;

243. Ялгаран гарсан хийг зайлуулах нөхцөлүүдийг (хаях газарт гэх мэт) Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

244. Дэлбэрэх аюултай ба галд аюултай бодисууд (ус төрөгч, хүхэрт нүүрстөрөгч, циант устөрөгч ба бусад) их хэмжээгээр ялгарч болохуйц аппаратуудын татах агааржуулалтын системийг угсрах, төхөөрөмжлөхдөө тэсрэх аюулгүй байдлыг ханган гүйцэтгэнэ.

245. Цианидтай орчинд ажиллаж байгаа ажилтанг хувийн хэмжих багажаар (цианид детектор) хангана.

246. Ажилтан цианидын уусмалтай (булингатай) шууд харьцахаас зайлсхийх, ажлын орчинд хор ялгарахыг бууруулахын тулд цианжуулах хэсгийн тоног төхөөрөмж ба сав нь битүүмжлэл сайтай, агааржуулалтын системээр тоноглогдсон байна. Технологийн процессын хяналт болон удирдлага нь бүрэн автоматчилагдсан байна.

247. Цианжуулах процессын тоног төхөөрөмж ба савнууд нь уусмал (булинга) хальж болзошгүй урьдчилан сануулсан автомат төхөөрөмж, хальсан уусмалыг буцааж сорох насос, дамжуулах хоолойгоор тоноглогдсон байна.

248. Цианидын уусмал буюу түүний ууртай харьцдаг тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулагч, дамжуулах хоолой, арматур бусад төхөөрөмж нь цианд уусдаг өнгөт төмөрлөг ба тэдгээрийн хайлшаар (зэс, зэс-цайр, хөнгөн цагаан ба бусад) хийсэн эд ангитай байж болохгүй.

249. Далдлаагүй ба шүүн агааржуулах тоног төхөөрөмжгүй тоноглол савнууд доторх цианы уусмал (зутан)-ын рН-ийн хэмжээ 10-10.5 хооронд байна.

250. Цианидын уусмал бэлтгэх хэсэгт сорох системээр зайлуулагдаж буй агаарыг байрны дээд орчноос авна. Агааржуулалтын системээр өгөх агаар нь ажил байнга явагдах байр ба замын орчин руу чиглэсэн байна.

251. Цайрын тунадсыг хатаах, нунтаглах, сорьцлох ба савлах байрууд нь цианжуулах хэсгээс тусгаарлагдсан, бохирдсон агаарыг цэвэрлэх шүүлтүүр бүхий агааржуулах системээр тоноглогдсон байна.

252. Цайрын тунадсыг вакуум хатаах зууханд хатаана. Зуухан дээр задгай хатаахыг хориглоно.

253. Хатаасан цайрын тунадастай савыг вакуум шүүгээнд хөргөнө.

254. Цианид агуулсан урсцыг саармагжуулах байр нь үйлдвэрлэлийн бусад байрнаас тусгаарлагдсан, аюулын үед хэрэглэх алсын удирдлагатай агааржуулах системээр тоноглогдсон байна.

255. Цианид агуулсан урсцыг зөвхөн агаар сорогч, хянах хэрэгсэл бүхий битүү тоног төхөөрөмжид саармагжуулна.

256. Үйлдвэрийн бүсээс ажлын тусгай хувцастай гарах, хувцсыг авч гарахыг хориглоно.

257. Цианидын уусмалд гараа буюу тусгай хувцас угаахыг хориглоно. Цианидын уусмал ба булингатай зөвхөн резинэн бээлийтэй харьцаж ажиллана.

258. Цианжуулах бүх хэсгүүдэд Яаралтай тусламж үзүүлэхэд зориулсан байр байгуулах ба уг байр нь цианид агуулсан ямар ч тоног төхөөрөмжөөс нь 25.0 метрээс ихгүй зайд байна. Байранд хүрэх зам нь гэрэлтүүлэгтэй, очиход саадгүй, тоног төхөөрөмж ба шугам хоолойгоор хаагдаагүй байна.

259. Яаралтай тусламж үзүүлэх байр нь хэрэглэх эм, боох материал, хор эсэргүүцэгч цуглуулга бүхий эмийн сан, хор эсэргүүцэгчийг хэрэглэх заавар, шаардагдах сав суулга, бусад хэрэгслээр хангагдсан байна. Яаралтай тусламж үзүүлэх байранд шалнаас 2.0 метр өндөрт орших түгээх хоолой руу холиураар дамжин өгөгдөх халуун ба хүйтэн устай байна. Түгээх хоолойд шүршүүр байрлуулахыг хориглоно.

260. Цианид түгээх ган нь урвалж найруулах талбайд байрлах ба өөрийн сорох агааржуулах төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Уг байр нь цоожтой байна.

261. Цианидын ба ксантогенатын уусмалыг хүчилтэй холихыг хориглоно.

262. Цианидыг хэрэглэх цэгт өгөх, дамжуулах хоолой нь цианидын уусмалд чөлөөтэй хүрэх боломжгүйгээр хийгдсэн байна. Урвалжийн өгч байгаа цэгт түүнийг хэмжихийг хориглоно.

4.1.1. Даралтат тоног төхөөрөмж

263. “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-д заасан шаардлагын дагуу тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах, хэмжих багажгүй болон хамгаалах хэрэгсэлгүй бол ажиллуулахыг хориглоно.

264. Автоклавын ажиллах ажилтан нь эрх бүхий үнэмлэхтэй байна.
265. Автоклаваас материалыг суллах буюу дүүргэх ажлыг гараар гүйцэтгэх бол 2-оос доошгүй тооны ажилтан байна.
266. Автоклав ажиллаж байхад коллектор болон автоклавын хаалт бусад хаалтыг цохиж онгойлгохыг хориглоно.
267. Дамжуулагч хоолойн жийргэвч, залгаасаар уусмал алдагдаж байвал коллекторт өгч буй уурын хаалтыг яаралтай хааж, автоклавын даралтыг агаарын даралтын хэмжээнд хүртэл бууруулна.
268. Автоклав, коллектор буюу уур хураагчид эвдрэл гарвал хураагч дахь өндөр даралттай уурыг хааж, автоклавын цахилгаан хөдөлгүүрийг салган, автоклавын даралтыг агаарын даралтын хэмжээнд хүртэл бууруулна.
269. Автоклав, коллекторыг засварлах, онгойлгохын өмнө даралтыг агаарын даралтын хэмжээнд хүртэл бууруулна. Автоклавын дотор талыг усаар угааж, хорт хийг уураар үлээлгэж зайлуулан түүнийг 40°C хүртэл хөргөсний дараа автоклавт засварчид орохыг зөвшөөрнө. Автоклавт залгасан бүх шугам хоолойг найдвартай тагласан байна.
270. Материалыг гаргахдаа таглааг нь сулладаг автоклавуудыг онгойлгох шаардлагатай.
271. Автоклавын таг, даралт ихэссэнээс болж онгойх, дутуу тагласан автоклавыг ажиллуулж, даралт өгснөөс болж, нээгдэхээс сэргийлэх хориг оньсоор тоноглогдсон байна. Хэрэв хориг оньс гэмтэлтэй бол автоклавыг ажиллуулахыг хориглоно.
272. Автоклаваас уусмалын сорьц авахдаа халсан шингэн асгарахааргүй хийгдсэн тусгай зориулалт бүхий сорьц авагчийг ашиглана.
273. Автоклавын овор хоорондын зай 1.0 метрээс багагүй байна. Автоклавын байгууламжийн дээд талын ажлын талбай нь агааржуулалтын системээр тоноглогдсон байна.
274. Автоклавын гагнуурын ширээсийг хялбархан шалгаж үзэхэд зориулагдсан гагнаасны дагуу салгаж авдаг дулаан тусгаарлагч хийгдсэн байна. Автоклав байрлуулсан байранд гагнуурын ширээсийг шалгахад зориулагдсан талбай хийгдсэн байна.
- 4.1.2. Шингээх, шингээлтийг алдагдуулах, сэргээх ба электролиз
275. Ажлын байрны агаарт их хортой бодис орохоос болгоомжлон хэсгийн тоног төхөөрөмж нь бүрэн бин битүүлэгдсэн байх ба хий соролт нь цуглуулах саравч доороос гүйцэтгэгдэнэ.
276. Шингээлтийг алдагдуулах ба сэргээх процессын хяналт болон удирдлага нь автоматчилагдсан байна.
277. Давирхайн өөрчлөлтийг харах цонх ба баганын таглаа нь битүүмжлэл сайтай байна.

278. Давирхайг өөр найрлагатай орчинд (шүлтээс хүчилд буюу эсрэг) тээвэрлэх явцад уусмалууд бүрэн тусгаарлагдсан байна. Уусмалыг давирхайтай хамт тээвэрлэхийг хориглоно.

279. Баганаас давирхай ба уусмалын сорьцыг зөвхөн таглаан дахь нээлхий буюу баганын хажуугийн хаалгаар дамжуулан авахыг зөвшөөрнө. Багана таглааг сорьц авахдаа онгойлгохыг хориглоно.

280. Шингээлтийг алдагдуулах ба сэргээх угаалгын хүчиллэг уусмалыг процесс руу буцаахдаа (шохой, идэмхий натри) саармагжуулсны дараа зөвшөөрнө.

281. Электролизын таваарын сэргээгчийн байр нь ерөнхий солилцооны ба ослын үеийн агааржуулалтын системээр тоноглогдсон ба агаарт хүчил, циант устөрөгчийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их болох үед дуут болон гэрлэн дохио өгөх хэрэгслээр тоноглогдсон байна.

282. Электролизын сөрөг туйлын (катод) хавтгайг солихдоо ажилчид резинэн тусгай хувцас (резинэн гутал, хормогч, бээлий) өмсөнө.

4.2. Дулааны аргаар боловсруулах

4.2.1. Хатаах, ууршуулах

283. Ууршуулагч төхөөрөмжийн хамгаалах хавхлага, таглаа, хэмжих багаж гэмтэлтэй, мөн задгай төхөөрөмж дээр сорох агааржуулалт зогссон, ажиглах цонхны шил гэмтэлтэй бол ажиллуулахыг хориглоно. Ууршуулагч төхөөрөмж дээр нээлхийнүүдийг байрлуулахдаа агаарын урсгал нэвт гарч байхаар байрлуулах ба хамгаалах хавхлагаас гаргах хоолойг байрнаас гадагш гаргаж хийсэн байна.

284. Ууршуулагч төхөөрөмжийн ажлын үед зөвхөн зориулалтын ажиглах цонхоор харахыг зөвшөөрнө. Төхөөрөмжийн гагнуурын ширээсийг шалгаж үзэхэд зориулсан шилжих байгууламжийг тоноглогдсон байна.

285. Ууршуулагч төхөөрөмжийг задлахын өмнө:

а. уурыг гаргаж, төхөөрөмж дэх даралтыг агаарын даралтын хэмжээнд хүртэл буурсныг шалгах.

б. уурын буюу шингэн дамжуулах хоолойг хааж найдвартай таглах.

в. төхөөрөмжийн доторх дулаан 40°C ихгүй байх шаардлагатай. Ууршуулагч төхөөрөмжийн цэвэрлэгээг эрх бүхий ажилтныг байлцуулан гүйцэтгэнэ.

286. Ууршуулагч төхөөрөмж дэх шингэний төвшин, нягтыг хэмжих, сорьц авах ажлуудыг автоматжуулаагүй бол уурыг хаасны дараа гүйцэтгэнэ.

287. Зуухны доторх дулаан 60°C-аас дээш байвал цэвэрлэгээ болон засварын ажил хийхийг хориглоно.

288. Зуухны ойролцоо асгарсан мазут дээр элс цацаж яаралтай зөөж зайлуулна.

289. Шингэн түлш хадгалагч саванд гал гарвал ослын үед гал унтраах системтэй байх эсвэл нөөц саванд юүлэн гал унтраах арга хэмжээ авах ба Онцгой байдлын албанд дуудлага өгнө.

290. Ажиллаж байгаа зуухны шингэн түлш цацагч (форсунк)-ийг тохируулахдаа, шингэн түлш цацагчийн цонхны зөвхөн хажуу талд зогсож гүйцэтгэх хэрэгтэй.

291. Зуухыг ажиллуулах, зогсоох ажиллагааг үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны баталсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

4.2.2. Бөөнцөглөх ба бөөгнөрүүлэх, ангижруулах шатаалтын төхөөрөмжүүд ба хатаах хэсэг

4.2.2.1. Бөөнцөглөх ба бөөгнөрүүлэх

292. Үндсэн түүхий эд, хольц, буцах ба дэвсгэр материалын бункерууд нь тоос, уур, хий ялгаруулалтыг арилгах шүүх төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Бункерын нүх 200х200 мм-ийн төмөр сараалжаар таглагдсан байна.

293. Конвейераар бункерт материал өгөх газар нь тоос ялгарах боломжгүй байхаар таглагдсан байна.

294. Холигч хүрдийг цэвэрлэх ба засварлахад хүмүүсийг оруулах зориулалттай нээлхийний хаалтууд нь орчны болон алсын удирдлагаар хаалга онгорхой үед залгагдахгүй байхаар хориг оньсоор хангагдсан байна. Холигчийг ажиллаж байх үед шууд хүрднээс сорьц авахыг хориглоно. Сорьц авалт нь автомат сорьц авагчийн тусламжтайгаар ба онцгой тохиолдолд хүрдний дараах хольцын урсгалаас авагдана.

295. Бөөнцөглөх ба холих машины зуухны галлуурт хий өгөхдөө «Хар төмөрлөг боловсруулах заводын хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм»-ийн дагуу явагдах ёстой. Машины зуухны галлуурыг асаахдаа дараах дарааллыг баримтлана. ж-ёстой. Үүнд:

Шатаах машинд

а. Шатаах машинд хий хүлээн авах ажлыг хийх ажлын тусгай зөвшөөрлийг ээлжийн дарга ба технологийн алба буюу үйлдвэрийн батлагдсан бусад хариуцлагатнууд өгнө.

б. Сорох-үлээх төхөөрөмжүүд (агааржуулагч, утаа сорогч ба сорох сэнс)-ийг ажилд залгах

в. Асаагчаар дайруулан хий үлээх

г. Коллектор дахь агаарын даралтыг шалгах ба асаагчаар дайруулан хий үлээлгийн төгсгөлийг тогтоох

д. Аюулгүй ажиллагааны автомат-хий ба агаарын даралтын бууралтыг дохиологчийн бүрэн бүтэн байдлыг шалгах

е. Вакуум-камерын хаалтыг онгойлгох

ё. Асаагуураар галлуурыг асааж, технологийн зураглалын дагуу дулааны горимыг тохируулах. Шаталтын тэргэнцрүүд нь бөөгнөдөсөөр (окатыш) дүүргэгдсэн байна. Зөвхөн бамбар тогтвортой асаж байхад галлуурт агаар оруулахыг зөвшөөрнө. Хуйлраа галлуурт урьдчилан агаар өгсөн байна. Хэлхээн дэх даралт хэвийн байх үед хийг аажуухан өгөх хэрэгтэй.

ж. Хэрэв агаар асахгүй буюу унтраад байвал түүний өгөлтийг зогсоож, зуухны хөндийг сайн үлээлгэн агааржуулах ба зөвхөн үүний дараа асаалтыг сэргээх. Хий өгөлтийг аврах албаны хүн байхад залгах хэрэгтэй.

Бөөнцөглөх машинд

а. Сорох сэнсийг ажиллуулах.

б. Зуухны доорх вакуум-камерын хаалтыг онгойлгох.

в. Зуухан доторх галлуур доор түүдэг асаах.

г. Агаарын оньсыг онгойлгох.

д. Аюулгүй ажиллагааны автомат-хий ба агаарын даралтын бууралтыг дохиологчийн бүрэн бүтэн байдлыг шалгах.

296. Галлуурт хийг зөвхөн сайн ассан түүдэг буюу тасралтгүй шаталтыг хангасан бусад арга хэмжээг авсан үед өгөхийг зөвшөөрнө. Хэлхээн дэх даралт хэвийн байх үед хийг аажуухан өгөх хэрэгтэй.

297. Зуухны хана хөрөөгүй үед богино хугацааны зогсолтын дараа хийг бамбараар асаахыг зөвшөөрнө.

298. Бөөнцөглөх машины галлуурыг зогсоохын тулд хийний, дараа нь агаарын оньсыг хаах шаардлагатай ба түүний дараа сорох-үлээх төхөөрөмж (сорох сэнс, агааржуулагч, утаа сорогч)-ийг зогсооно. Шатаах машиныг урсгал ба их засварт зогсоохын тулд, галлуурт байгалийн хий болон мазут өгөлтийг зогсоох, хаалт тавих ба асаагуурын дамжуулах коллекторт шинжилгээний дүн гарах хүртэл уураар үлээлгэсний дараа, зөвхөн сорох-үлээх төхөөрөмжийг зогсоохыг зөвшөөрнө. Үлээлтийн асаагуурыг онгорхой үлдээнэ.

299. Коллектор ба галлуурын хаалтад үйлчилгээ хийхэд түүнд тохиромжтой орох боломжоор хангасан байна. Шугамын шибэрийн удирдлагыг алсаас операторын өрөөнөөс удирдана. Түүнээс гадна хэрэгцээтэй үед гараар удирдахаар урьдчилан тохируулсан байна.

300. Форсункийг шингэн түлшээр асаахдаа дараах нөхцөлийг баримтлан гүйцэтгэх хэрэгтэй. Үүнд:

а. сорох-үлээх төхөөрөмжийг ажиллуулах замаар вакуумын системийг залгах зуухны хөндийг сайн агааржуулах, вакуум-камерын хаалтыг онгорхой байлгах.

б. шингэн түлшийг форсункт өгөхийн өмнө шаталтыг сайжруулахын тулд уур буюу шахсан агаар урьдчилан өгөх.

- в. шингэн түлшийг асаахдаа урт иштэй бамбараар гүйцэтгэх хэрэгтэй.
- г. хэрвээ түлш асахгүй буюу унтарвал түүний өгөлтийг зогсоон зуухны хөндийг сайн агааржуулах ба зөвхөн үүний дараа асаалтыг дахин сэргээнэ. Форсункийг ажиллуулах ба засварлах нөхцлөөр хангагдсан байх хэрэгтэй.

301. Мазут болон нефтийн бүтээгдэхүүн хадгалах савны түвшинг шилэн хэмжүүрээр хэмжихийг хориглоно. Савнаас түлш хальж асгарахаас урьдчилан сэргийлсэн тусгай зориулалтын халианы төмөр хоолой ба түвшин тодорхойлогчоор тоногдсон байх хэрэгтэй.

302. Шингэн хадгалах сав (бак) дотор орж засвар ба цэвэрлэгээний ажил хийхдээ үйлдвэрийн удирдлагын тусгай зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэнэ. Сав дотор ажиллагч нар нь шланган хий эсэргүүцэгч баг ба хамгаалах бүс бусад хамгаалалтын хэрэгслээр хангагдсан байх хэрэгтэй. Шингэн хадгалах саванд хүмүүс ажиллах үед бүх нээхийнүүд онгорхой байх ба тэдгээрийг зохих ёсны агааржуулалтаар хангасан байх хэрэгтэй. Шингэн хадгалах саванд ажил хийхэд зориулагдсан тэсрэлтээс хамгаалагдсан аккумуляторын гэрэл гэрэлтүүлэг хэрэглэнэ. Гэрлийг асааж унтраахыг бакны гадна талаас гүйцэтгэнэ. Сав дотор ил галтай орохыг хориглоно. Шингэн хадгалах саванд ажил хийж байгаа хүний ажиллагаанд тасралтгүй хяналт тавьж түүний хамгаалах бүсний оосроос барьж байх 2-оос доошгүй хүн савны гадна заавал байна.

303. Зуухыг засварлах үед түгээх савнаас шүршүүрт (форсункт) шатахуун хүргэдэг дамжуулах хоолойнууд нь хаалт болон бөглөөгөөр таглагдсан байх ёстой ба түүнчлэн шатахууны үлдэгдлээс суллагдсан байна. Ажлын сав нь аваарийн сав руу шатахуун юүлэх төхөөрөмжтэй байна.

304. Үйлдвэрийн хийн аж ахуйн ажилчид нь шаардлагатай хий хамгаалах аппаратаар хангагдсан байна. Харин ажлыг «Металл боловсруулах заводын хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм»-ийн шаардлагын дагуу хийнэ. Хийнээс хамгаалах аппаратууд нь машины ойролцоо тусгай газарт сайн хаагдсан саван дотор хадгалагдаж байх ба үе үе шалгагдаж байна.

305. Ажлын салаа руу тэргэнцэр гаргахад зориулж, нүхнүүдийг хаахын тулд тэргэнцэрт шагаж суулгагдсан нимгэн төмрөөр машины толгойн хэсэг халхлагдсан байна.

306. Шатаагч машины ачих хэсгийн нүүрэн тал нь ажлын үед машин руу хүн орохоос хамгаалан, ажлын салааны шалнаас хоосон салааны шалны түвшин хүртэл халхавчаар хаагдсан байх ёстой. Мөн шатаах машины хөтлүүрийн талбай хаалтаар хаагдсан байна. Тэргэнцэрт дэвсгэр ба бөөгнөдөс ачих газрын ажлын талбайн бүс нь ажилчин шатаах тэргэнцэрийн өнхрөвчөөс гэмтэл авахгүй байх хийцийн хаалттай байна. Өнхрөвч хураагчийн өнхрөвчийн хөтлүүр хаалтаар хаагдсан байна. Ажлын талбайгаас цухуйсан шатах машины толгойн хэсэг нь ажилчин ажиллаж байгаа машины савхан шүүр солих тэргэнцэр ажлын салаанаас гарах район руу болон бөөгнөдөс ачаалах механизмын үйлчлэлийн район руу орох явдлыг үгүйсгэсэн хаалттай байна. Шатаах машин ба зохих

хориг холбоонуудын төхөөрөмжүүдийг зогсоосны дараа эдгээр газарт хүн нэвтрэхийг зөвшөөрнө.

307. Шатаах машин ажиллаж байхад дараах зүйлийг хориглоно:

- а. Машины ажлын ба хоосон салааны рельс, шатаах тэргэнцэр ба тэргэнцрийн өнхрөвч дээр зогсох
- б. Шигшүүр ба ховилыг цэвэрлэх буюу савхан шигшүүрийг солих
- в. Шатаах тэргэнцрээс сорьц авах буюу өнхрөвчин хураагчаас тусгай төхөөрөмжгүйгээр сорьц авах
- г. Цахилгаан холболтыг нь салгаагүй ба машин ажиллаж байхад хоосон салаан дээр ба түүний доор зогсох
- д. Зуухны таг дээгүүр явах
- е. Цахилгаан хэрэгслүүдийг онгойлгож, ямар нэг утсыг сольж залгах
- ё. Хоосон салааны толгойн ба сүүлийн радиуст нэвтрэх
- ж. Галлуур ба зуухны сараалжид нүцгэн гараараа хүрэх түүнчлэн хий зайлуулагдаж байгаа ба эргэх агаарын дамжуулах хоолойнууд, батарейт циклоны их биед хүрэх
- з. Хий дамжуулагчийн ойр ил галтай байх
- и. Нээлхий, явуул зэргийг онгорхой орхих буюу шигшүүрийг машины холбирах ховилын нуувчийн эд ангиуд, хаалтуудыг авах
- й. Бөөнцөглөх машины ажлын салаан дээгүүр материал дундуур хөндлөн гарах

308. Атмосферт гаргаж байгаа агаар ба хаягдал хийнүүдийн цэвэрлэгээг тусгай төхөөрөмжид гүйцэтгэнэ.

309. Шатаах корпуст бөөгнөдөс ачих ба шатаах хэсгийн хооронд мөн түүнчлэн ажлын талбайнуудын хооронд гэрлэн ба дуут дохионууд телефон холбоотой байна.

310. Шигшүүр ховилд хажуугаас нь үйлчилгээ хийхэд тохиромжтой болгох, аюулгүй байдлыг хангахын тулд хашлагатай талбайг төхөөрөмжлөнө. Механик шигшүүрийн савааг засварын талбайд солих ба байран дээр засвар хийх шаардлага гарсан үед машиныг зогсоож, сүүлчийн тэргэнцрийг материалаас бүрэн чөлөөлж банзан шалавч төхөөрөмжилсний дараа засварыг гүйцэтгэнэ. Ажлыг нь хамгаалах бүс хэрэглэн гүйцэтгэнэ.

311. Шатаах тэргэнцрийн хоосон салааны төмөр замын ил хэсэг нь торон хаалтаар тусгаарлагдсан байх хэрэгтэй.

312. Буцаалтын бункер нь унжсан зүйл үүсгэхгүйгээр хийгдсэн байна. Хэрэв буцаалтын бункерт унжсан зүйл үүсвэл машиныг зогсоосны дараа материалыг буулгана. Буцах материалыг нураахад тусгай хэрэгслээр (шахмал агаар зэргээр) техникийн хяналтын ажилтны шууд удирдлага дор гүйцэтгэнэ. Энэ үед хүмүүсийг ачилтын бункерээс аюулгүй

зайд гаргасан байвал зохино. Ажиллаж байгаа машины буцах материал халсан гадаргуутай бункерт ус өгөхийг хориглоно.

313. Буцах материал, шигшүүр болон бункерыг усаар хөргөхдөө машиныг зогсоож, нэмэлт аюулгүй арга хэмжээ авч гүйцэтгэх хэрэгтэй. Буцах бункерт шилэн нээлхий төхөөрөмжилж болохгүй. Хэрэв буцаах бункерыг гараар шилээх шаардлага гарвал шигшүүрийг зогсоож, буцах материалыг хөргөн, аюулгүй ажиллагааг хангах нэмэлт арга хэмжээг, үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны баталсан тусгай зааварт тусгасан байна. Харах нээлхий болон тоноглолын бүрхүүлийн хажуу талд нь байрлуулан найдвартай түгжээ бүхий таг хийж өгнө.

314. Уур үүсгэх материал зөөх туузан дамжуулагчийн галерейн агаарын температур хүйтний улиралд 22°C-ээс багагүй байна. Үлээж байгаа агаарыг урьдчилан халаасан байна.

315. Хөргөлтийн хүрд нь нүүрэн талын уур, тоосыг ангижруулах зориулалттай нягт бүрээс бүхий сорох хоолойгоор хангагдсан байх хэрэгтэй.

316. Буцах материал, халуун тэжээгчийн орчинд байхдаа түүний буудахаас болгоомжлох шаардлагатай. Буцах материал өгөх нүхний эсрэг зогсохыг хориглоно.

317. Хөргүүрийн доогуур ажиллаж байгаа үед нь явахыг хориглоно. Хөргүүрийн эргэн тойрон түгжигддэг хаалгатай хаалт хийсэн байх хэрэгтэй. Хаалтын цаана байгаа хөргүүрийн аяганд орж тавган доор байрласан механизмд үйлчилгээ хийхэд зориулж тусгай далдалсан нуувчтай дөхөх төхөөрөмжтэй байна.

318. Бөөгнөдөс асгах шуудуу нь бэх бат хаалгаар тусгаарлагдсан байх хэрэгтэй.

319. Бөөгнөдөсөөс сорьцыг тусгай газар төхөөрөмжилсөн автомат сорьц авагчийн тусламжтай авах ба бөөгнөдөсийг цувуураар зөөдөггүй тохиолдолд гүүрэн краны хутгаар төмөр зам дээрх вагоноос сорьц авч болно.

320. Бөөгнөдөс ачих төмөр замын хэсгийг механик аргаар цэвэрлэнэ. Бөөгнөдөсийг зөөвөрлөхөд зориулан цоорхойгүй вагон ашиглах хэрэгтэй.

321. Атмосферт гаргаж байгаа агаар дахь тоосжилтын хэмжээ эрүүл ахуйн нормоос хэтрээгүй байна. Энэ зорилгоор тоос баригч төхөөрөмжийг шатаах машин хольц (шихта) бэлтгэх механизмын вакуум-камерт байрлуулна. Цацагдаж байгаа хийний тоосжилтын хэмжээнд хяналт тавих зорилгоор улиралд нэгээс доошгүй удаа сорьц авна.

322. Тоос суулгах төхөөрөмжийг усан ба хийн тээвэр бусад аргаар угааж цэвэрлэнэ. Тоос суулгах байгууламжаас тоосыг усан ба хийн тээврийн системд өгөхдөө орчны агаарыг тоосоор бохирдохоос хамгаалсан байна.

323. Шатаах байр, түүхий эд бэлтгэх тасаг болон бусад байранд байрласан хаягдал хийн, хий-агаарын цуглуур, тэдгээрийн бункерууд нь дулаан тусгаарлагчтай байх ба гадаргууны температур нь 45°C-ээс хэтрэхгүй байна. Дулаан тусгаарлагчийн гадаргууг тоосноос цэвэрлэхэд амар байхаар бодож гадаргууг нь хөнгөн цагааны хайлшаар бүрж

өгсөн байна. Тоос зайлуулах хий-агаарын цуглуурын хийц, рекуперацийн систем нь тэдгээрт тоос тогтоох бололцоогүй хийгдсэн байна.

324. Сорох-үлээх төхөөрөмж ажиллаж байгаа болон цахилгаан хөдөлгүүрийг салгаагүй үед тоос баригч цуглуур тэдгээрийн бункерт, нээлхийг онгойлгон үзлэг хийхийг хориглоно.

325. Тоос цэвэрлэх төхөөрөмж дотор талд цэвэрлэгээ, засвар хийх ажлыг хоёроос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй гүйцэтгэнэ. Энэ үед сорох-үлээх төхөөрөмжийн цахилгааны холболтыг салгасан байна.

326. Шинээр төсөл хийхдээ шатах зуухны сорох-үлээх төхөөрөмжийг тусгай байшинд эсвэл шатах байшин дотор зузаан ханаар тусгаарлан байрлуулна. Сорох үлээх төхөөрөмж байрласан өрөө нь шатаах хэсэгтэй гэрлэн ба дуут дохиоллын систем, телефон холбоогоор холбогдсон байна.

327. Хэвтээ хүхээтэй сорох үлээх төхөөрөмжийг холбосон хий дамжуулагч нь бин битүү хийгдсэн байна. Хүхээ нь шатаах корпусын барилга буюу сорох үлээх төхөөрөмжийн барилгын гадна байрлах ба хий нэвтрүүлдэггүй материалаар шавж байна. Корпус доторх хий дамжуулагчийг ердийн металлаар хийнэ.

328. Хий зайлуулах цуглуулуур болон сорох үлээх төхөөрөмжийн эхэн, төгсгөлд байрласан хаалтуудын удирдлага нь бүрэн механикжсан буюу цахилгаанжсан байна. Зайлуулагдаж байгаа хийн хэсэгт засварын ажил гүйцэтгэх буюу эксгаустерийн талаас хаалтад очихоос өмнө хүхээнээс шаталтын бүтээгдэхүүн нэвтрэхийг зайлуулахын тулд сорох үлээх төхөөрөмжийн роторыг солих ба утаа сорогч болон агааржуулагчийн зүгээс хаалт хийсэн байвал зохино.

329. Сорох үлээх төхөөрөмж нь чимээ тусгаарлах (намжаах) хэрэгслээр хийгдсэн байх ба түүнд ажиллагч хүний өрөөний ханыг мөн дуу тусгаарлагч зүйлээр хийсэн байвал зохино.

330. Холигч хүрдний ачих нүх, буцах материалын хөргүүрийн хүрдийг цэвэрлэхдээ хүрдний дотор байрлан гүйцэтгэхийг хориглоно.

331. Жин тугнуурыг шалгах, цэвэрлэхэд тэдний цахилгаан хөдөлгүүрийн гүйдлийг салгаж зогсоосны дараа гүйцэтгэх шаардлагатай.

332. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны баталсан тусгай зааврын дагуу хольц бүрэлдүүлэгчээс сорьц авах хэрэгтэй.

333. Шатаах машины бүтэц нь ашиглалтын явцад хий алдагдах ба байранд бөөгнөдөсний хайлсан үеэс дулаан ялгарахыг үгүйсгэх зорилгоор «зуух-шатаах тэргэнцэрийн» зангилгаан дахь ашигтай нягтрал хангагдах ёстой.

334. Шатаах машины зуухны өрлөгийн засварыг сорох үлээх төхөөрөмж, машины хөдөлгүүрийн цахилгааны холболтыг салгаж, хүйтэн агаар өгөх зөөврийн салхивчийг тавьж ажлын тусгай зөвшөөрөл өгсний дараа гүйцэтгэнэ.

335. Зуухны өрлөгийг усаар хөргөхийг хориглоно.

336. Шатаах машины зууханд ажиллахдаа 12 В-оос хэтрэхгүй хүчдэл бүхий хамгаалах тортой зөөврийн бүрэн бүтэн гэрлийг хэрэглэх шаардлагатай.

337. Шатаах машиныг ажиллаж байхад зуухны өрлөг нурах, байранд шаталтын бүтээгдэхүүн, дөл хаяхыг урьдчилан мэдэгдэх зорилгоор зуухан дээр хамгаалагч тэсрэлтийн хавхлага байрлуулах хэрэгтэй.

338. Шатаах машиныг зогсоох үед (ажлын салаан дээр хольц ба бөөгнөдөс байхад) вакуум-камерт сийрэгжилт 200 мм мөнгөн усны баганаас багагүй байх хэрэгтэй. Галлуурт өгч байгаа хий ба мазутыг зогсоосны дараа зөвхөн сорох үлээх төхөөрөмжийг зогсоох, мөн түүнчлэн түлшийг гүйцэд шатааж, бөглөө хийж, асаагч дайруулан коллекторт үлээлтийг зогсоосны дараа зөвшөөрнө.

339. Шатаах машины утаа сорогч, агааржуулагч буюу сорох сэнсний аль нэг зогссон үед:

- а. түлш өгөлтийг даруй автоматаар салгах, шатаах машин, бүх сорох үлээх төхөөрөмжийг автоматаар зогсоох
- б. хольц бүрдүүлэгчийн шаталтаас хий байранд ялгарахыг зогсоох зорилгоор шатаах машины ажлын салаа нь материалаас чөлөөлөгдсөн байна.
- в. хийн хаалтыг хаах ба асаагчийн хаалтыг онгойлгох замаар галлуурт өгч байгаа түлшний өгөлтийг зогсооно.

340. Утааны хоолой руу зайлуулагдаж байгаа агаар өгөх сорох-үлээх төхөөрөмжийг зогсооход хэвтээ хүхээний өмнөх хаалтыг зогсоосны дараа 30 минутаас доошгүй болгоод хаах хэрэгтэй.

341. Шатаах машины асгах ба толгойн хэсгүүдэд, бөөгнөдөсийн шигшүүр, бөөгнөдөсийн ховил, асгарсан зүйлийн цэвэрлэгээ нь сайн ажиллаж буй сорох салхилуурын системтэй холбогдсон бин битүү нуувчаар тусгаарлагдсан байна.

342. Машины толгойн хэсгээс асгарсан материалыг бункер доорх ховилоос зөвхөн тусгай угсрагдсан талбайгаас цэвэрлэхийг зөвшөөрнө.

А. Буцах дэвсгэр материал

343. Буцаалтын зангилгаанууд нь үйлдвэрийн бусад хэсгээс битүү тусгаарлагдсан байна. Шатаалтын ба буцаалтын тасгуудын хооронд шууд телефон холбоотой байна.

344. Буцаалтын зангилгаануудад байрлагдсан шүүх ба тоосны усан цэвэрлэгээний төхөөрөмжүүд нь хөдөлмөрийн хэвийн эрүүл ахуй ариун цэврийн нөхцөлийг хангасан байна.

345. Хангалтгүй буюу гэмтэлтэй агааржуулалттай үед буцаалтын зангилааг ажиллуулахыг хориглоно. Буцаалтын зангилгааны ажилчид нь нүдний хамгаалах шил хэрэглэнэ. Буцах халуун материалын бункер нь дулаан тусгаарлагдсан байна.

346. Хөргөгч хүрдэнд засвар болон цэвэрлэгээ хийж байх үед хүн оруулах зориулалттай нээлхийний хаалганууд нь онгорхой байхад хүрд залгагдахыг хориглосон, хориг оньс бүхий ойрын болон алсын удирдлагаар хангагдсан байна.

347. Буцах материалыг хөргөх зориулалттай төхөөрөмжүүд нь түүний температурыг эрүүл ахуй ариун цэврийн шаардлагыг хангах хүртэл бууруулдаг байна.

348. Б. Бөөгнөдөсийг хөргөх ба ачих

349. Бөөгнөдөс хөргөх процесс нь бөөгнөдөсийн температурын бууралтыг калориметрийн аргаар тодорхойлох бол 140°C-аас доош буухгүй байх нөхцөлийг байна.

350. Бөөгнөдөсийг вагонд ачих төмөр зам нь бүхээгтэй зонт байх ба тоостой агаарыг сорохдоо тусгай агааржуулагч хэрэглэж хаягдлыг тусгай төхөөрөмжөөр цэвэрлэнэ. Ачилтыг ажиглах зорилгоор телевизийн болон автомат хэрэгслүүд байрлуулах хэрэгтэй. Хөдөлмөрийн хэвийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг хангасан тусгай таслагдсан байрнаас ачилтыг удирдан гүйцэтгэнэ.

351. Бөөгнөдөсийн бункер нь зөвхөн материал хаяхад зориулагдсан нүхтэй бөгөөд нягтруулсан битүү хучилтаар таглагдсан байх ёстой. Нүхнүүд нь 200x200 мм нүдтэй төмөр тороор хаагдсан байна.

352. Тоос суулгах төхөөрөмжөөс зайлуулагдаж байгаа тоос нь шүүгдэх ёстой.

353. Буцах халуун материалыг туузан цувуураар тээвэрлэхдээ цувуурын туузан дээр урьдчилан дэвссэн хольц дээр түүнийг ачих ёстой.

354. Хөдөлмөрийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл нь мөрдөж бий ариун цэврийн нормыг хангасан ба мэргэжлийн байгууллагаар зохиогдсон зураг төсөлтэй үед хольцыг халаахад буцах материалыг ашиглахыг зөвшөөрнө.

355. Буцах халуун материалыг тээвэрлэхдээ цувуурын туузаас гоожуулж болохгүй.

356. Бөөнцөглөх үйлдвэрт, хүхрийн хүдрээс бөөгнөдөсийг үйлдвэрлэхдээ, хүхэр баригч төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

357. Бэлэн бөөгнөдөсийн шигших байр нь шатаалтын корпусаас ханаар тусгаарлагдсан байна. Шигшилтийн хэсэгт орох хаалга нь бин битүү өөрөө хаагддаг байна.

358. Хүрдний хөндийд үзлэг хийх үед 12В-оос илүүгүй хүчдэлтэй гэрэлтүүлэг хэрэглэх хэрэгтэй.

359. Бөөнцөглөх машины байр нь машины бөөнцөг асгах хэсгээс байшингийн бүх өндөртэй тэнцүү ханаар тусгаарлагдсан байна. Буулгах хэсгийн талбай руу орох хаалга нь бин битүү өөрөө хаагддаг байна.

360. Бөөнцөглөх машины буулгах хэсэг, бутлуур шигшүүр ба ховилууд нь шүүх системд холбогдсон бүрхүүлээр тусгаарлагдсан байна.

В. Асаалтын зуух

361. Бөөнцөглөх машины асаалтын зуухны хана, таазууд нь дулаан алдахгүй байна. Зуухны дээр байшингийн хамгийн өндөр хэсгээс дээш 1-2 м илүү гарсан сорох хоолойтой дефлектороор тоногдсон бүхээг (зонт) байрлуулсан байна.

362. Зуухтай залгаа байгаа бөсгөх машины дагуу улайссан хольцын бүх гадаргууг халхлах усан хөшиг хийж өгнө. Бөсгөх машины дагуу хийсэн халхыг асаах зууханд тулган хийсэн бол усаар хөргөх хөшиг хийх шаардлагагүй.

363. Асаалтын зуухны дулааны цацралтаас хамгаалахад зориулж нимгэн төмөр, шөрмөсөн чулуу буюу тороор самбар халхавч хийж усаар тасралтгүй шүршдэг байна.

Г. Шохойн шатаах

364. Шатаах төхөөрөмжийг ажиллаж байх үед хийн шугам сүлжээ ба шалгах хэмжих хэрэгслүүд дээр засварын ажил хийхийг хориглоно.

365. Шохой хэрэглэхийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл нь мөрдөж байгаа эрүүл ахуйн нормд тохирч шохойг хүлээн авах, түүнийг бөөгнөдөсийн хольцод холих зураг төсөлтэй үед зөвшөөрнө.

366. Ус хэрэглэж шохой задлахыг аюулгүй ажиллагааны нэмэгдэл арга хэмжээ авсан үед зөвшөөрнө.

367. Хангалтгүй болон гэмтэлтэй агааржуулалттай үед шохойн чулуу шатаах тасагт хүн ажиллахыг хориглоно.

368. Шохойн тоосролтыг арилгасан нөхцөлд тээвэрлэхийг зөвшөөрнө.

4.2.2.2. Ангижруулах шатаалтын төхөөрөмж

369. Ангижруулах шатаалтын төхөөрөмжийг ашиглахдаа хар төмөрлөг боловсруулах үйлдвэрийн хийн аж ахуй аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан, байгууллагын эрх бүхий ажилтнаар батлуулж, мөрдөж ажиллана.

4.2.2.3. Хатаах тасаг

370. Хатаах тоног төхөөрөмжүүдийн өндөр температурт үүсгэдэг бүх гадаргууг дулаан тусгаарлагчаар бүрсэн байх буюу хашлага хийсэн байна.

371. Хатаах буюу шатаах машинууд нь хянах, хэмжих (уурын халуун хэмжигч, хийний бүрэлдэхүүнийг тодорхойлогч) багажуудаар тоноглогдсон байна. Хэмжих, хянах багаж гэмтэлтэй нөхцөлд хатаах төхөөрөмжийг ажиллуулахыг хориглоно.

372. Галлах хэсэгт ажиллах талбайн хэмжээ нь хатаах байгууламжийн багажуудтай ажиллах аюулгүй нөхцөлийг хангасан байна.

373. Дулаан цацрагт ялгаралттай тэмцэхийн тулд ажлын байрыг агаарын шүршүүрээр тоногловсон байна.

374. Тоос гаргахгүйн тулд хатаах зууханд тэжээл өгч байгаа хоолой, ховилууд нь сорох агааржуулагчтай байна. Эргэх хүрдийг хотол ба буулгах камертай холбосон хэсгүүд нь бин битүүлэгдсэн байна.

375. Хатаах төхөөрөмж ба зуухнууд нь агаарыг тоос болон бусад хортой хольцоос салган ариун цэврийн нормд хүртэл цэвэрлэх төхөөрөмж бүхий хий сорогчоор тоногловдсон байна. Татах-үлээх системийг ажиллаагүй үед хатаах зуухыг ажиллуулахыг

хориглоно. Татах-үлээх төхөөрөмжийн ажиллагаа нь хатаах зуухнаас гарч буй ямар ч хийг ажлын байранд нэвтрэн орохгүй байх нөхцөлийг хангаж байна.

376. Үнсний болон шлакийн (шаар) бункеруудын хаалг онгорхой байх үед галлах хэсгийг шилээж болохгүй. Хатаах зуух ажиллаж байх үед хаалтыг нээлттэй байлгах, зуухны ёроолыг цэвэрлэх, шавцыг цохиж унагахыг хориглоно.

377. Хотол цэвэрлэх ажлыг зөвхөн бүх шатахууныг шатаж бүрэн дууссаны дараа үлээлтийг хаагаад гүйцэтгэж болно.

378. Гар багажууд, (хүрз, лантуу, царил)-ыг хөргөж байхын тулд галч-хатаагчийн ажлын байранд савтай ус тавьсан байна.

379. Үнсний болон шаарны бункерүүдийн гаргах сойлтууруудыг зөвхөн үлээлтийг зогсоосны дараа нээж болно.

380. Үнсний болон шаарны бункерүүдийг үнс, шаар асгах нүхээр нь сэтгэхийг хориглоно.

381. Гараар галладаг хотлын үнсийг цэвэрлэхийн тулд хотлын хаалгыг онгойлгох мөн үнсний хоёр амыг нэгэн зэрэг онгойлгохыг хориглоно.

382. Шавдас болон үнсийг зайлуулах ажил бүрэн механикжсан байна. Хэрэв механикжсан шаар үнс зайлуулагч байхгүй бол шаарыг зуухнаас гаргангуут усаар унтраах хэрэгтэй. Шаар (дутуу шатсан зүйлийг) унтраах газрыг сорогч төхөөрөмжөөр тоноглон байна.

383. Асгарсан мазутыг тэр дор нь элсээр хучиж дараа нь цэвэрлэх хэрэгтэй.

384. Мазутыг юүлэх ваарын сав хэт дүүрсэн буюу гэмтэлтэй нөхцөлд хотлын байгууламжийг ажиллуулахыг хориглоно. Хэрэв түгээгүүрийн саванд байгаа мазут шатаж эхэлбэл маш яаралтай бүх мазутыг аваарийн сав руу юүлж галыг унтраах арга хэмжээ авах ба гал команд дуудах хэрэгтэй.

4.2.2.4. Хатаах тасгийн тоног төхөөрөмжид үзлэг хийх, нэг хэсгийг нь задлах, чигжээс таваг холбоос солих зогсоохдоо бүх мазут дамжуулах хоолой, түгээх, савуудыг султгаж тэдгээрийг тунадас үлдэгдлээс нь сайн цэвэрлээд халуун уураар үлээлгэхийн зэрэгцээ хөдөлгүүрүүдийг унтрааж гүйдлээс бүрэн салгасан байна.

4.2.2.5. Тоосго шатаах

385. Тоосго шатаах төхөөрөмжийг ашиглахдаа аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан, байгууллагын эрх бүхий ажилтнаар батлуулж, мөрдөж ажиллана.

Бүлэг - V Үйлдвэрийн тээвэр

5.1. Технологийн тээвэр

386. Үйлдвэрийн мэдэлд хамаарах төмөр зам, барилга байгууламж хөдлөх бүрэлдэхүүн, холбоо, дохиолол болон хоригт оньс, тэрчлэн галт тэрэгний хөдөлгөөнийг удирдах байгууллага, ачих буулгах ажиллагаанд “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-ийг баримтлан ажиллана.

387. Ачаа ачих буулгах хэсэгт вагон тавих, гаргах ажлын механикжилтын тоног, төхөөрөмж болон байгууламжийг хаалт халхавчаар хамгаалсан байна.

388. Авто тээврээр материал зөөвөрлөхөд “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”-ийн дагуу зохицуулна.

389. Үйлдвэрийн талбай доторх хоосон болон ачаатай автомашин, галт тэрэгний хөдөлгөөний журам болон хурдыг тухайн үйлдвэрийн газраас өөрийн газар орны онцлог байдалд тохируулан тогтоосон зааврын дагуу зохицуулна.

390. Үйлдвэрийн талбай доторх төмөр замын хүмүүс хөндлөн гарах хэсэгт дамжлага гүүр болон хонгил барьсан байна. Дээрх байгууламжийг барих боломжгүй нөхцөлд галт тэрэгний ойртох хөдөлгөөнийг мэдээлсэн гэрлэн болон дуут дохиоллын систем тавьсан байна.

391. Ачих, буулгах зорилгоор өөрөө буулгагч автомашин болон төмөр замын вагоныг үйлдвэрийн байр руу оруулахад тэдгээрийн хөдөлгөөнийг уг байранд нь үйлчилж байгаа ажилчны удирдлагаар өгсөн гэрлэн дохиогоор гүйцэтгэнэ.

392. Тоосорхог материалыг ачих ба буулгахад тоосноос хамгаалах хэрэгслийг хэрэглэхээс гадна тоос дарах арга хэмжээ авсан байх шаардлагатай.

5.2. Тасралтгүй тээвэр (туузан дамжуулагчид, шугам хоолойгоор дамжуулах-хийн, шингэн, булингын-slurry)

393. Туузан дамжуурга болон бусад тасралтгүй тээврийн төрлүүдийн аюулгүй ашиглалт, бүрэн бүтэн байдалд тавих хяналтыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан хариуцна.

394. Туузан дамжуургын тууз урагдах, хий эргэх, хазайлт мэдрэгч идэвхжих, чангалуурын татлага тасрах тэрчлэн туузан дамжуургаас хүдэр буух урсгуур буюу ховил бөглөрөх тохиолдолд дамжуургыг автоматаар зогсоох хориг тавьсан байна.

395. Туузан дамжуурга болон хүрдэнд наалдаж тогтсон материалыг механик аргаар цэвэрлэх төхөөрөмж тавьсан байна.

396. Туузан дамжуургын асгагч тэргэнцрийн явалтыг хязгаарласан төгсгөлийн салгуур тавьсан байна. Асгах тэргэнцэр түүнчлэн байнга шилжилтийн байдалд ажилладаг дамжуулагчийн цахилгаан хөдөлгүүрүүдэд, хүчдэл өгөх шланган утсыг өндөрт дүүжлэн байрлуулна. Автоматаар сэлгэн явдаг тэргэнцэр болон шилжих туузан дамжуургын цахилгаан хөдөлгүүрт цахилгаан хүчдэлийг үйлчлэх талбайгаас 3.5 метр өндөрт байрласан, авцалдаат дамжуулагчийг ашиглан өгөхийг зөвшөөрнө.

Хэрэв хүчдэл дамжуулагч троллейны шугам нь бага өндөрт (3.5 метрээс 2.2 метрт) байрласан байвал тусгай хаалтаар халхалсан байна. Асгах тэргэнцэрт санамсаргүй хөдөлгөхийг хориглосон тусгай төхөөрөмжийг тавьж өгнө.

397. Туузан дамжуурга нь хаалт хашилтаар хамгаалагдаж тусгаарлагдсан, ажиллаж байгаа үед цэвэрлэгээ хийх боломжгүйгээр хийгдсэн байна. Туузан дамжуургыг гар аргаар

цэвэрлэхдээ тусгаарлалтын журмын дагуу хүчдэлээс нь салгаж холбогдох арга хэмжээг авна.

398. Ажиллаж байгаа туузан дамжуургын тууз хазайсан үед туузын хөдөлгөөнийг гараар чиглүүлэх, түүнийг тусгай төхөөрөмжгүйгээр засахыг хориглоно. Туузан дамжуургын туузыг гулсаж хажуу тийш гаргахгүйн тулд түүний холбиролтыг хязгаарлах төхөөрөмжөөр тоноглогсон байна.

399. Туузын хий эргэлтийг зогсоохын тулд хөтлөгч хүрдний гадаргуу дээр ямар нэгэн материал түрхэхийг хориглоно. Туузын хий эргэлтийг эсрэг ачаа буюу чангалагчийн тусламжтайгаар арилгана. Хүрд болон тууз нь тээвэрлэгдэж байгаа материалаар дарагдсан нөхцөлд дамжуургыг ажиллуулахыг хориглоно. Хөтлүүрийн хүрдний эргэх тэнхлэг шалнаас 1.5 метрийн өндөрт байрласан тохиолдолд хөтлүүрийг засвар үйлчилгээ хийхэд зориулсан хашлагатай шатаар тоноглогдсон тавцанг ашиглана.

400. Галерей ба эстакадын доторх таазны өндрийн хэмжээ 2.0 метрээс доошгүй, өргөний хэмжээг түүний доторх үйлчилгээний зайг тооцон дараах шаардлагыг харгалзан тогтооно. Үүнд:

а. Туузын өргөн 1400 мм хүртэл бол нэг талд 0.8 метрээс багагүй, нөгөө тал нь 0.7 метрээс багагүй, 1400 мм-ээс их бол хоёр талын зай тус бүр нь 0.8 метрээс багагүй байна.

б. Хоёр ба түүнээс дээш тооны зэрэгцээ дамжуургын хоорондын зай 1.0 метрээс багагүй байхаас гадна өргөн 1400 мм хүртэл бол түүний суурь ба хана хоорондын зай 0.7 метрээс багагүй, дамжуургын туузын өргөн нь 1400 мм-ээс их бол 0.8 метрээс багагүй байна.

401. Хавтант тэжээгүүрийг байрлуулахдаа бүх талаас нь үйлчилгээ хийх боломжтой байна. Хавтант тэжээгүүрийн хоорондох замын өргөний хэмжээ 1.2 метрээс багагүй, барилгын хана ба тэжээгүүрийн хоорондох зай нь 1.0 метрээс багагүй байна.

402. Налуу тавьсан хавтант тэжээгүүрийн татах төхөөрөмжийн эд анги нь тасрах үед дамжуургын гинж нь буцаж гулсахаас хамгаалсан баригчаар тоноглогдсон байна.

403. Шурган дамжуургыг байрлуулахдаа түүний нэг талаас нь үйлчилгээ хийхэд зориулсан 0.8 метрээс багагүй зайг гаргана. Шурган дамжуурга нь таг, хориг, оньсоор тоноглогдсон байхаас гадна ажлын үед эргэлдэж байгаа шурганд хүрэх боломжгүйгээр хийгдсэн байна.

404. Дамжуургын галерей нь газар доороос, газрын гадаргууд үргэлжлэн гарч байхаар баригдсан байвал уг галерейд гаднаас орох хаалга, дамжуурга дээгүүр дамжих гүүрийг байрлуулсан байна.

405. Галерей болон эстакадад байрлах дамжуурга дээгүүр дамжин гарах гарц болон гүүр 100 метр тутамд байрлуулсан байна. Гүүрний өргөний хэмжээ 800 мм бөгөөд 1000 мм-ээс багагүй өндөр хашлага доороосоо 140 мм өндөр хөндлөвч бүхий шалтай байна.

406. 7°-аас дээш налуутай дамжуургын галерейд шаталсан гишгүүр болон шат хийсэн байна.
407. Тоос, хий ялгаруулагч материал тээвэрлэдэг дамжуургын галерейн, барилга байгууламжтай нийлсэн хэсгийг өөрөө хаагдагч хаалга бүхий хаалтаар халхалсан байна. Хаалтаар дамжуурга нэвтрэх нүхний хэмжээ хамгийн бага байна.
408. 6°-аас дээш налуутай бүх туузан ба Хавтан дамжуурга нь дамжуургыг зогсоох үед ачаатай туузын буцаж явах хөдөлгөөнийг зогсоогч төхөөрөмжөөр тоноглогсон байна.
409. Туузан дамжуурга дээр материалыг гараар ялгаж байгаа үед түүний хурдыг 0.5 м/с-ээс хэтрүүлж болохгүй. Гар ялгалт хийж байгаа дамжуургын туузын хэсгийг хаалтаар хамгаалсан байна.
410. Дамжуургыг гарц болон тоног төхөөрөмж дээгүүр гарч байхаар байрлуулсан тохиолдолд түүний доод хэсгийг материал асгарч гоожихоос болгоомжилж битүү халхавчаар хамгаалсан байна.
411. Туузан дамжуургаар хуурай, тоосорхог материал өндөр температуртай ба уур гаргах материалыг тээвэрлэхэд материал ачих буулгах хэсгийг битүүлэн хааж, тоос шүүх, ус шүрших байгууламж, шалыг усаар угаах зэрэг агаар дахь тоосны хөнөөлтэй хольцыг зөвшөөрөгдсөн хэмжилтээс хэтрүүлэхгүй байх зорилгоор бусад нэмэгдэл арга хэмжээг авсан байх шаардлагатай. Нунтаг, тоосорхог хуурай материалыг тээвэрлэхэд туузын материал зөөвөрлөх хэсгийг бүхэлд нь битүүлсэн байна.
412. Хуурай тоосорхог материалыг тээвэрлэж байгаа мушгиат, шанагат зөөгч, хусуурт (скребковый) дамжуургыг уртааш нь бүрхэж хаасан байх ба материал орж гарч байгаа хэсгийг сайтар битүүлсэн байна. Шанагат зөөгчийн ажиллагааг хянахад зориулж түүний бүрхэвч дээр нягт хаагдагч хаалттай харах цонхыг гаргасан байна.
413. Нойтон материалыг тээвэрлэхэд түүний үсэрч цацагдах явдлаас болгоомжилж шанагат зөөгчийг туушид нь хамгаалах бүрхэвчээр хаасан байх шаардлагатай. Шанагат зөөгчийн ачих, буулгах цэгт аваарын салгуур байрлуулсан байна.
414. Угсраа байрласан хэд хэдэн дамжуурга бусад машин тоног төхөөрөмжтэй зэрэг ажиллах нөхцөлд тэдгээрийн хөдөлгүүрийн ажиллагаа нь хориг оньст удирдлагаар залгагддаг байх шаардлагатай. Үүнд:
- а. зогсоох, ажиллуулах дэс дарааллыг үйлдвэрийн технологийн схемийн дагуу гүйцэтгэнэ.
 - б. аль нэг машин ба дамжуурга гэнэт зогсох нөхцөлд түүний өмнө байрласан тоног төхөөрөмж буюу дамжуурга автоматаар салгагдан зогсохоор тоноглогдсон байна.
 - в. дамжуурга болон бусад тоног төхөөрөмжийн дэргэд төв удирдлагаас ирсэн залгах командыг салгах гар удирдлагатай хориг оньс байрлуулсан байна.

415. Бүх дамжуурга нь уртынхаа дагуу аль ч цэгээс зогсоож болох салгах төхөөрөмжтэй байна.
416. Шанагат зөөгч зогсох үед буцаж явахаас хамгаалсан зогсоох төхөөрөмжөөр тоноглогдсон байхаас гадна шанаганы гинж тасрахад уг гинжийг барих тогтоогчоор тоноглогдсон байна.
417. Материал асгарч болзошгүй дамжуургын хэсэгт урьдчилан хамгаалах хашилттай байна.
418. Өөрөө буулгах тэргэнцэр болон хөдөлгөөнт дамжуургын урсгуур нь битүү байх ба төмөр замын рельсээс 10 мм-ээс ихгүй зайтай байна.
419. Дамжуургыг чангалах төхөөрөмжийн ачаа болон хүрдийг хашлагаар хаасан байх ба тууз буюу татлага тасрахад доод давхарт байгаа тоног төхөөрөмж болон хүмүүс дээр унахааргүйгээр байрлуулсан байна.

Бүлэг - VI Хаягдлын аж ахуй

420. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаягдлыг хадгалах газар болон бүх төрлийн гидротехникийн байгууламжийн төсөл, ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох дүрэм, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
421. Баяжуулах, боловсруулах үйлдвэр нь хаягдлын аж ахуйн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавартай байна.
422. Эстакад, гүүр, далан, ухсан нүх дээгүүр тавьсан хаягдал дамжуулах хоолойн дагуу түүнийг аюулгүй үйлчлэхийн тулд 0.7 метрээс доошгүй өргөнтэй явуул гаргана. Эстакад, гүүр дээгүүрх гарц нь 1.0 метрээс доошгүй өндөр хашлагатай байна. Эстакад, хоолой дээгүүр давах ба хаягдал дамжуулагч дээгүүр дамжин явахыг хориглоно.
423. Хаягдлын санд тунасан усыг зайлуулах хоолой, мөн түүнчлэн хаягдал дамжуулах хоолойнууд тавьсан хонгил (туннель) нь гэрэлтүүлэг, агааржуулалтаар тоноглогдсон байна.
424. Тунасан усыг түгээх газрын ус хүлээн авах худгуудад ажилтан орох, гарах бариул хийх ба цуглуулах газарт (коллектор)-т гаднын хөвсөн зүйлс орохоос урьдчилан сэргийлж хөвөх байгууламжаар хамгаалсан байна.
425. Эрэг, ус хүлээн авах худаг хоёрын хооронд холбосон гүүрийн өргөн нь 1.0 метрээс багагүй, хашлагын өндөр нь 1.0 метрээс доошгүй байна.
426. Хаягдал болон эргэлтийн усан сангуудын хөвөгч хэрэгсэл нь бүрэн бүтэн, ачааны даацыг заасан бичигтэй байхаас гадна аврах зүйлс (аврах цагираг, олсон аргамж, ус юүлэх хутгуур) байна.
427. Хаягдлын сангийн тунасан элсэн хэсгүүд дээгүүр явган хүмүүс явахад хангалттай даах чадваргүй бол хашилт хийж, тэдгээрт анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна. Хаягдлын сангийн тунасан хэсэгт ажил хийхийн тулд хашлагатай гүүр байгуулах хэрэгтэй.

Тунгаах цөөрмийн ус мөн хаягдлын санд үүссэн нэвчилт, цөмрөлт, нүхэнд ойртож очих, түүнчлэн тунгаах цөөрмийн мөсөн дээгүүр явахыг хориглоно.

428. Тунгаах цөөрмийн усны хамгийн дээд төвшин далангийн тунасан нуруунаас 1.5 м-ээс багагүй доор байх ёстой ба хаялганы (пляж) өргөн нь хаягдал хадгалах газрын далангийн тунааж эхлэх үеийн өндрийг 2.5 дахин авснаас доошгүй байна. Хаягдлын сангийн далангийн орчим элс тунаах ажлыг жилийн дулааны улиралд гүйцэтгэнэ. Хоногийн агаарын дундаж температур -5°C -ээс доош байхад хаягдлыг бөөгнөрүүлэн хаяхыг хориглоно. Зураг төслийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр онцгой тохиолдолд гаднах агаарын температур -10°C хүртэл байхад бөөгнөрүүлсэн хаялт хийхийг зөвшөөрнө.

429. Хаягдал хадгалах газрын тунгаах цөөрмүүдэд усанд орох, хаягдлын сангийн усыг ундны зориулалтаар болон мал, амьтан услахыг хориглоно.

430. Хаягдлын насосын станцын байранд насосын агрегатуудыг аюулгүй ажиллуулах заавар, дамжуулах хоолойн шугамд нээх, хаах крантын бүдүүвчийг өлгөсөн байна. Хаах, тохируулах төхөөрөмж нь ажиллахад аюулгүй, гэмтэлгүй байна.

431. Хаягдлын сангийн гадаргуугаас тоос дэгдэлтийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

432. Хаягдлын сангийн далангийн ойролцоо тэсэлгээний ажил гүйцэтгэхдээ, зөвхөн түүний тогтвортой байхыг нотолсон тооцооны дараа гүйцэтгэнэ.

433. Хаягдлын усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхээр бол “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус” стандартыг баримтлана.

Бүлэг - VII Туслах үйл ажиллагаа

7.1. Усгүйжүүлэх

7.1.1. Өтгөрүүлэх

434. Пирамид ба тэвш хэлбэртэй тунгаагч, дугуй өтгөрүүлэгчийн амсар нь ажлын талбайгаас дээш 1.0 метрээс ихгүй өндөрт бол хашлага хийх шаардлагатай. Дээрээсээ таглаатай пирамид тунгаагчийн ирмэгийн дагуу хашлага хийх шаардлагагүй боловч засварын ажилд зориулсан нээлхий, нүхнүүд төмөр таглаатай байна.

435. Пирамид ба тэвш хэлбэртэй тунгаагч, дугуй өтгөрүүлэгчийн ирмэг дээгүүр явахыг хориглоно.

436. Булингын нягтыг хэмжих, сорьц авахдаа халианы ховил дээр зогсох, хамуурын талбайн хашлага дотор орохыг хориглоно. Захын хөтлүүртэй өтгөрүүлэгчийн хөдөлгөөнт хамуур дээр гарахдаа хашлагатай зориулалтын шат хэрэглэнэ. Хамуурын зөвхөн хөдөлгөөнт рамын цахилгаан холболтыг салгаж зогсоосны дараа өтгөрүүлэгчийн халианы ховилыг цэвэрлэж болно. Өтгөрүүлэгчийн хөтлүүрийн төхөөрөмжийн үйлчлэх талбайгаар баяжмалын хөөс нойтон халтиргаатай материал байгаа үед явахыг хориглоно.

437. Усгүйжүүлэх шигшүүрийн талбайгаар материалыг жигд тараахад зориулагдсан төхөөрөмжийн хийц нь материал үсрэх, булингыг цацагдахаас хамгаалсан байна.

7.1.2. Шүүх

438. Шүүх тоног төхөөрөмжийн ашиглалтын үед рам, шүүгч даавуунд наалдсан баяжмалыг цэвэрлэхдээ зориулалтын тусгай хүрз ашиглана.

439. Шахуурган шүүлтүүрийг задлахын өмнө даралтад хийгээр үлээлгэж, шингэн байхгүй болтол цэвэрлээд, задлах ажлыг хоёроос доошгүй хүн гүйцэтгэнэ.

440. Шахуурган шүүлтүүрийг үлээлгэх үед шингэн цацагдахаас болгоомжилж даавуугаар бүтээсэн байх шаардлагатай.

441. Хорт хий ялгаруулдаг материал шүүх тоног төхөөрөмж ажиллаж байх үед сорох агааржуулагч зогсолтгүй ажиллаж байна. Нутч-шүүлтүүр нь заавал таглаагаар таглагдсан байна.

442. Хүрдэн шүүлтүүрийн даавуунд шүүгдсэн баяжмалын үлдэгдлийг угаах төхөөрөмж байвал тэнд байгаа ажилтныг цацалтаас хамгаалсан хаалт хийсэн байна.

443. Сугардаг рамтай нимгэн хавтгай шүүлтүүрт наалдсан материалыг угаахад тохиромжтой байнгын талбай гаргасан байна. Ажлын үед центрифуг таг онгойхоос урьдчилан сэргийлж, хөдөлгүүртэй хориг оньсон холбоо хийсэн байна.

444. Центрифуг нь хэт буюу жигд бус ачааллын үед гэрлэн ба дуут дохио өгөх болон автоматаар зогсох төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

445. Тогтмол биш ажиллагаатай центрифугийг ажиллуулах үед материал агуулагч их биеийг гараар урьдчилан эргүүлж хөдөлгөөнд оруулах шаардлагатай.

446. Хориглох зүйлүүд:

- а. материал агуулагч сав жигд биш ачаалалтай үед ажиллуулах
- б. ажиллаж байхад таглааг онгойлгох
- в. өтгөрсөн материалыг гараар ухаж гаргах

447. Центрифугийн хүрд хөдөлгөөнтэй буюу чичиргээтэй байгаа үед ажиллуулж болохгүй. Хүрдэнд чичиргээ үүссэн тохиолдолд центрифугийг зогсоох хэрэгтэй.

7.2. Хүдэр, баяжмал болон хүдрийн бус материалын агуулах

448. Экскаватор болон ачигч ажилладаг агуулахад “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм”-ийг баримтлана.

449. Агуулах доорх галерей нь халаалтын болон ус зайлуулахаас гадна тоос цуглуулах системтэй байна.

450. Харанхуй үед агуулахын ажлын талбайг гэрэлтүүлсэн байна.

451. Нуруулдагчийн тусламжтайгаар агуулахад нуруу байгуулахад төмөр зам, ус хураагуурын сувгийг булаах, ажлын талбай, зам шатыг мөстүүлэхийг хориглоно.

452. Нунтаг материалыг хийгээр тээвэрлэхэд шугам хоолой, түүний холбоос, асгах газар, агуулахын битүүмжлэлийг хангаж, илүүдэл агаарыг шүүх системээр тоноглогдсон байна.
453. Талькийн хүдэр, каолин зэргийг нүүрс, цемент, шохойн агуулахын ойролцоо хадгалж болохгүй.
454. Тальк, каолин, бал чулууг тээврийн хэрэгсэлд задгайгаар ачихдаа тоос дарах арга хэмжээ авна.
455. Анхдагч түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний агуулахад хураасан материалын нурууны ташуу хажуу дээгүүр зөвшөөрөлгүйгээр явахыг хориглоно.
456. Харанхуй үед агуулахын төмөр зам, ачих техник болон тээврийн хэрэгслийн ажлын талбайг гэрэлтүүлсэн байна.
457. Ачих техник болон тээврийн хэрэгслийн ажлын бүсэд хүн нэвтрэхийг хориглоно.
458. Ачих техник болон шилжүүлэн ачигчаар төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд материалыг ачиж буулгахад “Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм”-нд заасан дохиог ашиглана.
459. Олон утгууртай ачих техник болон шилжүүлэн ачигч ажиллаж байгаа аюултай бүсэд хүн байхыг хориглоно.
460. Бүтээгдэхүүнийг ачих, буулгах үед ажлын орчны агаарын найрлагыг стандарт шаардлага нийцүүлэх арга хэмжээг авна.
461. Бульдозер ажиллах үед овоолсон материалын налуу дээшээ түрэх үед 25°, доош нь түрэх (ачаатай доош) үед 30°-аас илүүгүй өнцөгтэй байна. Бункерт материал ачих үед орох замын налуу 6°-аас дээшгүй байна.
462. Явган хүний болон автомашины замыг агуулах талаас хаалт, хашилтаар хамгаалсан байна.
463. Хөдөлгөөнт бункер буюу роторон экскаватор, туузан конвейераар шууд дүүргэгддэг агуулахын материал асгарах амсар нь байнгын хашлагаар хаагдсан, 200х200 мм-ийн тороор таглагдсан байна.
- а. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний сорьцлолт, савлалтад тавих шаардлага
464. Технологийн дамжлагын сорьцлолтыг үйлдвэрийн технологи хариуцсан албан тушаалтны баталсан тодорхой цэгүүдэд гүйцэтгэнэ. Заагдаагүй цэгээс буюу тоноглогдоогүй байрнаас сорьц авахыг хориглоно.
465. Сорьц авах цэгийн ажлын байр нь хүрэхэд хялбар, аюулгүй нөхцөлийг хангасан байхаас гадна тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт эд анги нь хаалт хамгаалалттай, зориулалтын гэрэлтүүлэгтэй байна.

466. Савлах хэсэг нь таваарын бүтээгдэхүүний агуулахаас тусгаарлагдсан байх бөгөөд конвейераар нэвтрэх хананы нүхэнд тусгай халхавч, хөшиг унжуулан тоос тархахаас хамгаалсан байна.

467. Бэлэн бүтээгдэхүүн савласан уутыг шахуурт дамжуургад оруулах зориулалтын чиглүүлэгч механизм тавигдсан байна. Шахуурт дамжуургыг ажиллаж байх үед савласан бүтээгдэхүүнтэй уутыг гараар чиглүүлэх, татаж буулгахыг хориглоно.

Бүлэг - VIII Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

468. Энэ дүрмийн заалтыг зөрчсөн ажилтан, үүрэг даалгавар өгсөн болон геологи, уул уурхайн улсын хяналтын асуудал хариуцсан байгууллагаас зогсоосон ажлыг дур мэдэн явуулсан удирдах болон инженер техникийн ажилтныг дүрмийн заалт зөрчсөнд тооцно.

469. Энэ дүрмийн заалтыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.